


ШИНЭ НОМЫН МЭДЭЭ

2020 №02



Эмхтгэсэн: Ном зүйч С.Найгалмаа

Улаанбаатар хот
2020 он

ГАРЧИГ

ФИЗИК-МАТЕМАТИКИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	1
ГЕОЛОГИ, ГАЗАРЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН.....	1
БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	1-3
РАДИО ЭЛЕКТРОНИК.....	3
ХӨДӨӨ АЖ АХУЙН ШИНЖЛЭХ УХААН.....	3
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААН.....	4
НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	4
ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	4-7
ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	8-11
УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	11-12
ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН.....	12-14
ЦЭРГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	14-16
СОЁЛ СУДЛАЛ.....	16
ШИНЖЛЭХ УХААН СУДЛАЛ.....	16-18
СЭТГҮҮЛ ЗҮЙ.....	18
ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН.....	19-24
УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ.....	25-26
УРАН ЗОХИОЛ.....	26-31
УРЛАГ. УРЛАГ СУДЛАЛ.....	31-33
ШАШИН СУДЛАЛ.....	33-34
ГҮН УХААН.....	34-35
СЭТГЭЛ СУДЛАЛ.....	36
НОМ ЗҮЙН ЛАВЛАГААНЫ ГАРЫН АВЛАГА.....	36

Товчилсон үгийн тайлбар:

БУУТ- Байгалийн ухааны уншлагын танхим /306 тоот/

НХУУТ- Нийгэм, хүмүүнлэгийн ухааны уншлагын танхим- I,II /211, 108 тоот/

ГНОФ- Гэрээр ном олгох фонд-I,II,III /110,201,401 тоот/

ГФ- Гадаад номын фонд /411 тоот/

ЛавФ- Лавлагааны фонд /409 тоот/

ЭШФ- Эрдэм шинжилгээний фонд /411 тоот/

БС- Бизнесийн сургуулийн номын сан /Хич-V 505 тоот/

ХЗС- Хууль зүйн сургуулийн номын сан /Хич-III 205 тоот/

ОУХНУС- Олон улсын харилцаа, Нийтийн удирдлагын
сургуулийн номын сан /Хич-V 304 тоот/

ФИЗИК-МАТЕМАТИКИЙН ШИНЖЛЭХ УХААН

Даваадулам Ж. **Олон хувьсагчийн функцийн дифференциал ба интеграл тоолол** / Хян. Ц.Лхамсүрэн.- УБ.: МУИС пресс, 2019.- 263х.- ISBN: 978-9919-21-424-1.



МУИС-ийн хөтөлбөрийн шинэчлэл ба сургалтын технологийн дэвшлийн зорилтод нийцүүлэн толилуулж буй энэхүү сурах бичгийн эхний хэсэгт олон хувьсагчийн функцийн дифференциал тооллын стандарт материалыг бүрэн дүүрэн багтаан оруулсан бөгөөд 2-р хэсэгт давхар интегралын байгууламж болон интегралын бусад хувилбаруудыг багтаасан ба мөн онолын материалыг бататгах түгээмэл хэв шинжийн, шилж сонгогдсон, сургамжтай жишээнүүдийг оруулж өгчээ.

22.161.1я73

Д 121

/БУУТ-12, ГНОФ-15/

ЭШФ Т-23451-23453

ГЕОЛОГИ, ГАЗАРЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН

Вэнзирски Пэтер **Хориотой аялал=Die verbotene reise:** Адал явдалт орголтын түүх=Die geschichte einer abenteuerlichen flucht / Ред. Б.Ундрах, Д.Очирмаа; Эх бэлт. С.Батжаргал; Орч. Б.Халиунаа.- УБ.: Монсудар, 2019.- 292х.- ISBN: 978-99973-1-782-7.



1987 оны зун Зүүн Берлиний оюутнууд болох Йенс, Мари нар Зүүн Герман дахь амьдралаа хэтэрхий давчуу баригдмал гэж үзэн гайхалтай адал явдал эрэлхийлэхээр зориглож, тэд Монгол улсад зочлох урилгыг хуурамчаар үйлдэн Улаанбаатар луу аялах виз, паспорттай болж чаддаг. Монголын үзэсгэлэнт байгалиар хэдэн долоо хоногийн турш аялсныхаа дараа тэд Хятад улсыг зорьсон гайхалтай аялалын талаархи үнэн бодит түүхийг энэ номонд өгүүлжээ.

26.89

В 97

/БУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б-29728-29730

БИОЛОГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Тунгалаг Р. **Монголын ургамлын аймаг:** 12-р дэвтэр: Amaranthaceae Juss: Magnoliophyta (Magnoliopsida) / Ерөн. ред. М.Ургамал; Дугаарын ред. Ч.Дуламсүрэн; Техник ред. Т.Мөнх-Эрдэнэ; Диз. Ц.Амартүвшин.- УБ.: Бэмби сан, 2020.- 133х.- (Монгол Улс Шинжлэх Ухааны Академи. Ботаникийн Цэцэрлэгт Хүрээлэн).- ISBN: 978-99962-3-829-1.



Манай орны ургамлын аймгийн томоохон овгуудын нэг болох Гагадайн (Amaranthaceae) овгийн 29 төрөлд багтах 102 зүйл тус бүрийн дэлгэрэнгүй ойллого, ургах хугацаа ба орчин, монгол орны болон ерөнхий тархалт, ховордлын статус зэрэг мэдээллүүдийг багтаасан. (71 зүйл ургамлын бүтцийн 19 зураг, 35 зүйл ургамлын тархалтын цэгэн 35 картыг хавсаргав).

28.58(1)

T 671

/БУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23457-23459

Алтанцэцэг Х. **Микологи: Сурах бичиг** / Ред. Ц.Жамсран, Б.Чимид.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 172х.- ISBN: 978-9978-740-4-7.



Мөөг судлалын талаар монгол хэл дээр гарч байгаа анхны энэхүү сурах бичиг нь их дээд сургуулийн оюутан, магистрант, докторант, эрдэм шинжилгээний ажилтан, мэргэжлийн хүмүүст зориулагдсан болно. Энэ сурах бичигт мөөгний өвчин үүсгэгч болон хортой, ашиггүй талыг нь дурдах төдий оруулж, харин мөөгний ашиг тус болон мөөгийг хоол хүнс, эрүүл мэндийн салбарт хэрхэн ашиглаж байгаа талаар дэлгэрэнгүй өгүүлжээ.

28.591я73

A 486

/БУУТ-3/

ЭШФ Т-23443-23444

Цэцэгмаа Д. **Монгол орны хөх ногоон замаг таних бичиг** / Ред. Ш.Дариймаа.- УБ., 2018.- 106х.- ISBN: 978-99978-967-4-2.



Замаг судлаач, гидробиологич, ургамал судлаач болон биологийн чиглэлийн мэргэжлийн багш, оюутнуудад зориулагдсан энэхүү бүтээлд монгол орны нуур, гол, рашаан ус, хөрсөнд тэмдэглэгдсэн 2 овог, 40 төрөл, 144 зүйлийн хөх ногоон замагийн таних түлхүүрийг тодорхойлон, зүйл тус бүрийн ургах орчин, өвөрмөц онцлогийг зургийн хамт оруулжээ. Нэр томьёоны тайлбар болон хөх ногоон замагийн латин нэрийн хэлхээсийг хавсралт хэсэгт оруулж өгчээ.

28.591(1)

Ц 975

/БУУТ-7/

ЭШФ Т-23445-23447

Гантигмаа Ч. ба бус. **Монгол орны цох: Б.1** / Б.Энхтуяа, Л.Жаргалсайхан; Хян. Ч.Гантигмаа.- УБ., 2019.- 216х.: Зур.- ISBN: 978-9919-22-658-9.



Монгол орны цохын багийн 10, овгийн 43 төрөлд хамрагдах 203 зүйлийн усны цохын биеийн бүтэц, биологи, амьдралын хэв маяг, амьдрах орчин, тодорхойлох түлхүүр бичиг, түлхүүрт ашиглагдаж буй шинж тэмдгийн дүрслэл зураг, гадаад шинж тэмдгийг тодорхойлсон дүрслэл бичвэр, тэдгээрийн тархалтын мэдээг нэгтгэсэн газрын зураг сэлтийг тус номонд оруулсан байна. Энэхүү ном нь байгаль орчны мэргэжилтэн, биологчид, их дээд сургуулийн оюутнууд болон байгаль сонирхон судлагч хүн бүхэнд гарын авлага болох ажээ.

28.691.89(1)

Г 233

/БУУТ-7/

ЭШФ Б-29709-29711

Хүний бие хэрхэн ажилладаг вэ= How the body works: Зургаар тайлбарласан баримтууд / Англи хэлнээс орч. А.Гиймэл; Эх бэлт. С.Батжаргал, Б.Төгсжаргал; Зөвлөгч. ред. S. Brewer; Ред. W.Horobin, A.Szudek.- УБ.: Мон судар, 2018.- 255х.- ISBN: 978-99973-1-571-7.

Хүний биеийн бүтцийн тухай ойлгоход хялбар энгийн хэллэгтэй, сонирхолтой байдлаар тайлбарласан энэхүү зурагт альбом нь уншигч танд бидний бие организм хэрхэн ажилладаг тухай гайхалтай нууц болоод нарийн төвөгтэй үйл ажиллагааны талаар ойлголт өгөх болно.

28.706

X 828

/БУУТ-5, ГНОФ-4/ ЭШФ Т-23448-23450



РАДИО ЭЛЕКТРОНИК

Сувдаа Б. **Компьютерийн хэрэглээ**: Үндсэн ойлголтууд / Ред. Ж.Пүрэв.- УБ.: Битпресс, 2019.- 154х.- ISBN: 978-99973-3-968-3.

Энэхүү гарын авлагад компьютерийн үндсэн ойлголт, Windows үйлдлийн систем, интернет орчинд ажиллах шинэ боломжууд болон MS Office-ийн програмуудаас бичвэр боловсруулах, хүснэгтэн мэдээлэл, илтгэл тайлан боловсруулах зэрэгт түлхүү хэрэглэгддэг Word 2010, Excel 2010, Powerpoint 2010 програмын талаар дэлгэрэнгүй тайлбарлан оруулжээ. Үг хэллэгийг хэрхэн орчуулж монголчилсон талаар, мөн гарны хос товчлуураар хэрхэн ажиллаж болох талаар сүүлийн бүлгүүдэд оруулж өгснөөр хэрэглэгчид цаашид компьютерийн үг хэллэгийг ерөнхийд нь ойлгоход мөн хурдан ажиллаж сурахад түлхэц болох ажээ.

32.973я7

C 685

/ГНОФ-10/

ЭШФ Т-23347-23349



ХӨДӨӨ АЖ АХУЙН ШИНЖЛЭХ УХААН

Баянчулуун Б. **Аж ахуйн тэмдэглэл** / Эрхлэн хэвл. Б.Лхагвадорж, Н.Цэцэн; Ред. Орч. Н.Цэцэн; Хөрв. Э.Жигмэддорж; Эх бэлт. Д.Өлзийбүрэн.- УБ.: Тод бичиг, 2019.- 148х.- ISBN: 978-9919-21-214-8.

"Аж ахуйн тэмдэглэл" нь 1936 онд Монгол улсын Шинжлэх ухааны хүрээлэнгээс Монголын хуучин мал маллагааны зүйлүүдийг бүртгэн тэмдэглэх зорилго тавьж, хүрээлэнгийн гишүүн Буянчуулган хэмээх хүнээр бичүүлсэн Цахарын аж ахуйг тэмдэглэсэн зохиол болно. Буянчуулган гуай бол Цахар ястан, Цахар баруун гарын Шулуун шар хошууны хүн юм. Тус тэмдэглэл нь Өвөр Монголын Баруун сахар нутагт тариалах соёл, арилжаа худалдаа хэдийд үүссэн, Цахарчууд хэзээ хэдий тооны хүмүүс Монгол улсад дагаар орсон, хаагуур нутагшсан, мал аж ахуй болон тариалангийн ажлыг хэрхэн эрхэлж байсан талаар судлаачдад судлан шинжлэхэд гэрч баримттай судалгааны материал болно гэж ном бүтээгчдийн зүгээс үзэж энэхүү бүтээлийг эмхэлж найруулан орчуулж уншигч танаа өргөн барьж байгаа ажээ.

40(1)

Б 819

/БУУТ-6/

ЭШФ Б-29662-29664



АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААН

Циммэр Карл. **Вирусийн ертөнц = A planet of viruses** / Орч. Э.Пүрэвдаваа; Ред. Р.Туул, В.Уянга; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Нэпко, 2019.- 165х.- ISBN: 978-9919-500-26-9.



Үеийн үед хүн төрөлхтнийг өвчлүүлсээр ирсэн энгийн ханиаднаас эхлээд Эбола өвчин, Дундад Дорнодын амьсгалын дутагдлын хамшинж буюу MERS, Чикунгунья вирусийн халдвар, өнөө үеийн хуягт гүрвэл, заан, хүн болоод амьтны ерөнхий өвөгт зуун сая гаруй жилийн өмнө халдварлан өвчлүүлж байсан эртний вирус, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалан үхлийн аюултай халдварт өвчин үүсгэдэг вирус болон вирусын даяарчлалын талаар энэхүү номонд өгүүлжээ. Түүнчлэн орчин үеийн биологийн ухааны ололт, вирусын халдвартай тэмцэх ирээдүйн арга, туршилтын талаар дурдсан байна.

52.64

Ц 603

/БУУТ-5, ГНОФ-4/

ЭШФ Б-29706-29708

НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААН

Төмөр-Очир С. **Ерөнхий хийгээд боловсролын социологи: Сурах бичиг** / Ред. Т.Цэнд-Аюуш.- УБ.: ЗГ-ын хэвлэх үйлдвэр, 2020.- 472х.- ISBN: 978-9919-23-117-0.



Нийгмийн амьдралд боловсролын гүйцэтгэх үүрэг, байр суурь, зорилт, асуудал хийгээд зөрчил, түүнийг шийдвэрлэх арга зам, хямралт төлөв байдлаас гарах арга, боловсролын хүрээнд багтаж буй социал нийтлэгийн үйл ажиллагааны хэлбэр, харилцан үйлчлэлийн үйл явц, боловсролын бололцоот хувьсалт өөрчлөлтийг төлөгчлөх мөн монголын боловсролын хөгжиж ирсэн түүх, өнөөгийн байдал, ирээдүйн төлөв байдлын талаар уг номонд тусгажээ.

60.56я73

Т 587

/НХУУТ-7/

ЭШФ Т-23437-23439

ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААН

Аким Г. **Зосон зургийн хойноос "Жаран" голыг гэтлэсэн аян: Түүхийн бүдгэрснийг тодлохуй-5=A journey over "Sixty" rivers in pursuit of ochre drawings: Clarifying faded of history-5** / Ариутгасан Р.Даваажав; Орч. Га.Дэлгэрмаа; Гэрэл зургийг Го.Аким; Эх бэлт. Б.Гантулга.- УБ.: Ганпринт, 2018.- 159х.- ISBN:978-99978-69-44-9.



Г.Аким гуай эх орныхоо өргөн уудам тал нутгаар хэрэн хэсүүчилж, жар гаруй гол мөрнийг гэтлэн, найман мянга гаруй километр замыг туулж, өдгөө зарим нь арилж балрахын ирмэгт тулсан хадны зосон зураг бичээсийг судалж, баримтжуулсан байдаг. Тэрээр “Жаран голыг гэтэлсэн аян”-аас нийт 20 гаруй хадны зосон зургийн тухай энэ бүтээлдээ оруулжээ. Зосон

зургийг боржин чулуун дээр зурсан учраас чулууны өнгөр арилж түүхийн дурсгал алга болох аюул нүүрлэсэн байгааг анхааруштай. Ийнхүү зосон зургийн тухай товчхон атугай өгүүлэх энэхүү бүтээл нь хойч үеийнхэнд түүхээ танин мэдэхэд зохих хэмжээнд тус болох буй заа.

63.2(1)

А 396

ЭШФ Б-29668-29670

Аким Г. **Дархад бөөгийн онгод тэнгэрээс тамлагаан дуудна уу:** Шаштирт Шишгид Шогч дархад / Ариутгасан Ч.Дүүжий; Хян. Е.Жаргалмаа; Эрхлэн хэвл. П.Цагаан; Гэрэл зургийг Г.Аким; Цахимаар урласан Т.Жархын; Монгол бичгээр урласан; Б.Хишигсүрэн.- УБ.: Би Си Ай, 2019.- 88х.- ISBN: 978-9919-9514-2-9.



Хөвсгөл нутгийнхаа алаг чулуу бүрийг мэдэх Чинос Чулуун Дүүжийн хэлсэнчлэн Монголын бичиг номын гэгээрсэн сэхээтэн Го.Аким Шишхэд нутгийн хад чулуутай ярилцсан тэмдэглэлээ “Дархад бөөгийн онгод тэнгэрээс тамлагаан дуудна уу” нэртэйгээр бүтээсэн аян замын хоёр дахь тэмдэглэлээ уншигч та бүхэнд толилуулж байна.

63.2(1)

А 396

/НХУУТ-3/

ЭШФ Б-29671-29673

Аким Г. **Тэнгэрээс залрагсдын "мөр"-ийг "тэнгэрийн хүүхдийн наадгай"-гаар мөшгөхүй=Tracing the "Footprints" of those who came from the sky through the "Toy of heaven's children":** Өөр гарагийнхан Оор Монголд бууж байсан тухай онцын зоригтой таамнал=A very brave hypothesis on Aliens that landed in Mongolia / Ариутгасан Д.Цэрэнсодном; Орч. Га.Дэлгэрмаа; Гэрэл зургийг Го.Аким; Хян. Ц.Баянмөнх; Цахим урлаач И.Р.Даваажав.- УБ.: Ган принт, 2017.- 147х.- ISBN: 978-99978-0-426-6.



Хатагин овогт Готовын Аким гуай монгол орны говь тал хээрээр хэрэн явж илрүүлэн олсон, хадны зурагнууддаа хийсэн судалгаа шинжилгээндээ суурилан энэхүү бүтээлээ туурвижээ. Өвгөн бичээч тус бүтээлдээ хадны зураг бол эртний хүмүүсийн зураг үсгээр туурвисан судар ном мөн гэж тэмдэглээд хадны зурагт байдаг олон тэмдэгтүүд өдгөө хятад, солонгос, япончуудын хэрэглэж буй дүрс үсгийн эртний хэлбэр болохыг дурдсан байна. Энэхүү бэсрэг номыг судлаачид, нийт уншигч сонирхогчдод зориулсан агаад хүн төрөлхтөн, тэдний салшгүй хэсэг бидний монголчуудын үе үеийн түүхэнд тэнгэр, одот ертөнцийг танин мэдэх төдийгүй ойлгодог байсныг нотлох олон үйл явц өнгөрсөн түүхэнд болсоор байсан эш баримтыг тусгажээ.


63.2(1)

А 396

ЭШФ Б-29665-29667

Монголчууд: Б.6: Социалист бүтээн байгуулалт (1960-1989) / Уран сайхны ред. Р.Энхбат Хариуцлагатай ред. С.Ууганбаяр; Эх бэлт. Б.Баясгалан; Газрын зургийн ред. Ш.Болормаа; Зур. Э.Базаррагчаа, Б.Төрмөнх.- УБ.: Монсудар, 2020.- 232х.- ISBN: 978-99973-1-426-0.

2010 оноос эхэлсэн “Монголчууд” төслийн хүрээнд Монгол нутагт хүн амьдарч эхэлсэн цагаас эхлэн 1990 оныг хүртэлх монголчуудын түүхийг харуулсан таван боть бүтээл өмнө нь гарсан бөгөөд энэ удаагийн 6-р ботид Монгол Улс гурав дахь Үндсэн хуулиа баталж, мал аж ахуйн орноос хөдөө аж ахуйн орон болох зорилт тавьсан 1960 оноос нийгмээрээ өөрчлөгдсөн 1990 он хүртэлхи цаг үеийн социалист бүтээн байгуулалтын тухай түүхийг өгүүлжээ.



63.3(1)

М 694

/НХУУТ-10/

ЭШФ Т-23507-23509

Түрэг, уйгур судлал-2019 / Ред. Ц.Баттулга; Эмхт. Б.Аззаяа.- УБ.: Удам соёл, 2020.- 126х.- ISBN: 978-9919-23-454-6.



Энэхүү бүтээлд эртний улс болох Түрэг, Уйгурын бичиг үсгийн дурсгал, бөө мөргөл, оршуулгын зан үйл, Хүннү гүрнээс улбаатай эртний хаад ноёдын хот суурины хамгаалалт, мөн энэ үеэс эхлэн хаад ноёдын орд өргөөг барихдаа тэднийг хамгаалах асуудлыг давхар бодолцохын зэрэгцээ үүгээр дамжин хамгаалалтын тогтолцоо бий болсон талаар тодорхой тусган харуулжээ.

63.3(1)

Т 807

ЭШФ Т-23468-23470

Халхын голын дайн-80 жил: Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл / Эмхт. Т.Уранчимэг, Ц.Бямба-Эрдэнэ; Хян. Ч.Баттулга, Т.Сүхбаатар; Ред. Ж.Базарсүрэн, Т.Эрдэнэхишиг; Эх бэлт. Д.Насанжаргал.- УБ.: ҮБХИС-ийн хэвлэх үйлдвэр, 2019.- 362х.- (Батлан Хамгаалах Яам. Үндэсний Батлан Хамгаалах Их Сургууль. Батлан Хамгаалах Эрдэм Шинжилгээний Хүрээлэн).- ISBN: 978-9919-9560-1-1.



Тус эмхэтгэлд Халхын голын дайн-80 жил сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүд, Халхын голын дайны түүх судлаач монгол болон гадаадын эрдэмтэн судлаачдын илтгэл өгүүлүүд багтсан байна.

63.3(1)

Х 197

ЭШФ Т-23474

Эрдэнэбат Д. **Шинэ эргэлтийн бодлого: Түүх, эдийн засгийн судалгаа** / Хян. Ч.Дашдаваа, З.Лонжид; Эх бэлт. Ч.Самбууням.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 215х.- ISBN: 978-9919-23-482-9.



Уг бүтээлд Монгол улс Оросын большевикуудаас бүрэн хараат байж улс төр, эдийн засаг, нийгэм, шашин соёлын бүх асуудлыг тэдний заавар чанд хяналтын дор хэрэгжүүлж байсан төдийгүй 1921 оноос эхлэн большевикууд өөрсдийн бүрэн эрхт төлөөлөгчөө Монголд байнга суулгаж, Монголын төр захиргаа эдийн засаг, соёлын байгууллагад ажиллаж байсан орос зөвлөх, сургагч, мэргэжилтнүүдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж байсан талаар дурджээ.

63.3(1)62

Э 739

/НХУУТ-7, ГНОФ-8/

ЭШФ Т-23488-23490

Амьдрал таньсан хүнээс суралцах бичиг: Таныг амьдралд бэлдэх ном.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 83х.- (Ухаарлын ном: Б.1).- ISBN: 978-99978-4-785-0.

Залуу хойч үеийнхнийг зөв үзэл, зөв бодол, зөв тэмүүлэлд хөтлөх үүднээс олны танил, алдартай, нэр хүндтэй хүмүүстэй хийсэн ярилцлага, намтраас бүтсэн таныг амьдралд бэлдэх энэхүү номонд алдартнуудын амьдралын ухаан, туршлага, үзэл бодол, ухаарал хайрлах онч үг сургаалууд багтсан байна.



63.3(1)-8

A 574

/НХУУТ-3/

ЭШФ Б-29749-29750

Улаанбаатар хотын өв соёлоос=Heritage of Ulaanbaatar city: Соёл судлал хичээлийн хүрээнд бэлтгэсэн гарын авлага / Эрхлэн удирдаж, хян. Л.Хэрлэн; Эмхт. Б.Гансүх, С.Ургамалцэцэг, А.Дуламжав.- УБ.: Удам соёл, 2019.- 227х.- ISBN: 978-9919-23-332-7.



Улаанбаатар хотын 6 дүүрэг дэх соёлын дурсгалт өв болох хөшөө дурсгал, сүм хийд, музей, театр, барилга байгууламж, цогцолбор газруудын тухай товчхон түүхийг монгол, англи хэлээр эмхэтгэн энэ номонд оруулжээ. Уг гарын авлага нь МУИС-ийн "Соёл судлал" хичээлийн хүрээнд суралцагч оюутнуудын хийсэн хамтын бүтээл бөгөөд УБ хотын соёлын дурсгалт газруудтай танилцах, мэдээлэл авах хүсэлтэй хэн бүхэнд зориулав.

63.3(1-2УБ)лб

У 295

/НХУУТ-3, ГНОФ-5/

ЭШФ Б-29759-29760

Монгол соёл иргэншил судлал: Ерөнхий суурь боловсрол эзэмшихэд зориулсан их сургуулийн сурах бичиг / Г.Нандинбилиг, С.Дулам, С.Дашдэжид ба бус.- УБ.: МУИС пресс, 2020.- 448х.- ISBN: 978-9919-504-12-0.



Энэхүү бүтээлд монгол соёл иргэншлийн ялгаатай өвөрмөц чанар, эрхлэх аж ахуй, соёл сэтгэлгээний суурь хүчин зүйлсийг шинжлэхийн хамтаар монгол үндэсний ижилсэл-ондоошлын асуудалд анхаарал хандуулж, монголчуудын эрхлэх аж ахуй, байгаль, цаг уурын онцлог, соёл шүтлэг болон "Цагаан сар"-ын зан үйл цаашлаад "Наадам" хэмээх үндэсний их баяр цэнгүүн зэрэг соёлын шинэ зан үйлүүдээр дамжуулан монголчууд амьдралын үндсэн утга, үзэл суртлаа хэрхэн бүрдүүлж байгаа талаар авч үзжээ.

63.5(1)я73


М 692

/НХУУТ-27, ГНОФ-70/

ЭШФ Т-23280-23282

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Ринчинбазар Р. **Бүс нутгийн шинжлэх ухааны үндэс** / Ред. Б.Чинбат; Эх бэлт. С.Нарантуяа, Х.Эрдэнэбулган, Б.Уранчимэг; Хян. Д.Мөнхжаргал, А.Цэрэнлхам; Хавтасны диз. С.Нарантуяа, Б.Алтантуяа; Зур. схемийг Д.Мөнхсайхан, Х.Билгүүн, Б.Лхагвасүрэн.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 480х.- ISBN: 978-99978-805-3-6.



Бүс нутгийн шинжлэх ухааны судлах зүйлд хамаарах бүсчилсэн хөгжлийн онол, арга зүй, нутаг дэвсгэрийн орон зайн зохион байгуулалт, хот судлал, бүс нутгийн эдийн засгийн шинжилгээ, загварчлал, хөгжлийн үзүүлэлтүүд, хөгжлийн зорилго, шалгуур, нөлөөлөх хүчин зүйлс, бизнесийн орчныг үнэлэх арга зүй, хөгжлийн төлөвлөлт, прогноз, стратеги, бүс хоорондын харилцаа, бүсийн нутгийн хөгжлийг дэмжих, зохицуулах болон удирдлагын арга механизм хийгээд Монгол улсын өнөөгийн эдийн засгийн макро бүсүүдийн нөөц, чадавхын үнэлгээ, тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх арга зам, бүсчилсэн хөгжлийн бодлогын нөхцөл байдлын шинжилгээ, бүсчлэлийн бодлого үр дүнтэй хэрэгжүүлж буй зарим орны туршлагын талаар тус номонд өгүүлжээ.

65.04

P 516

/БУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Т-23454-23456

Нямаа Д. **Ахисан түвшний санхүүгийн нягтлан бодох бүртгэл**: Сурах бичиг / Ред. Р.Бадамханд; Диз. Т.Тэмүүжин.- 7 дахь хэвл.- УБ.: МУИС пресс, 2020.- 216х.- ISBN: 978-9919-23-557-4.



Бизнесийн эдийн засгийн мэргэжлээр их, дээд сургуульд суралцаж байгаа оюутан суралцагчид, магистрант, докторант, мэргэжлийн нягтлан бодогчид, санхүүчдэд зориулан тус сурах бичгийг толилуулж байна. Сурах бичиг 10 бүлгээс бүрдсэн бөгөөд бүлэг тус бүрийг үндсэн ойлголт, түүнийг хэрэглэх жишээгээр баяжуулан тайлбарласан ба бүлгийн төгсгөлд энгийн болон бодолттой тест, дасгал бодлогуудыг хариуны хамт оруулжээ.

65.052я729

H 985

/НХУУТ-3, БС-5/

ЭШФ Т-23462-23463

Үнэлгээний олон улсын стандарт 2020 оны 01 дүгээр сарын 31-нээс хүчин төгөлдөр болно.- 5 дахь хэвл.- Норвич Пейж Брос, 2019.-166х.- ISBN: 978-0-9931513-3-3-0.



Энэ номонд "Үнэлгээний олон улсын стандарт"-ын шалган магадлалт, тайлагнал, үнэ цэнийн сууриуд, биет бус хөрөнгө, санхүүгийн бус өр төлбөр, үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоо, санхүүгийн хэрэглүүртэй холбогдолтой 101-105, 200, 210, 220, 300, 400, 410, 500 гэсэн стандартууд тус тус оржээ.

65.052ц

Y 837

/БС -3/

ЭШФ Т-23433-23434

Энхбат А. ба бус. **Хөрөнгө оруулалтын төслийн зардал-үр ашгийн шинжилгээний арга зүй** / Д.Деррин, Д.Баттулга; Ред. А.Энхбат; Диз. Э.Одончимэг.- УБ., 2019.- 143х.- ISBN: 978-9919-2277-60.



Орчин үеийн эдийн засагт хөрөнгө оруулалтын аливаа шийдвэр гаргахад тухайн төсөл, хөтөлбөрийн үр ашгийн шинжилгээний асуудал чухал байдаг. Энэхүү гарын авлага нь улсын салбарын буюу улсын төсвийн болон төрийн өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрийг сонгон шалгаруулахад техник эдийн засгийн үнэлгээний аргачлалуудыг хэрхэн хийх талаар танилцуулсан болно.


65.26-56

Э 66

/НХУУТ-3, БС-5/

ЭШФ Т-23435-23436

Боди З., Мертон Р.К. **Санхүү** / Хян. А.Ганзориг, Г.Буянтогтох, Ж.Ариунболд ба бус.; Орч. А.Ганзориг Ж.Ариунболд Ч.Аварзэд ба бус.- УБ.: Мөнхийн Үсэг, 2018.- 636х.- ISBN: 978-99978-3-675-5.



Тус бүтээлд санхүүгийн ухааны ойлголт, тогтолцоо, хөрөнгө оруулалт, хувьцаа болон орчин үед санхүүгийн мэргэжилтний санааг зовоосон олон асуудалд холбогдох хувь хүний санхүү, капиталыг төсөвлөх, үйлдвэрлэх ажлын эдийн засаг, аж ахуйн нэгжийн ажлын үр ашгийг шинжлэх зэрэг агуулгыг багтаасан байна.

65.261я73

Б-53

/НХУУТ-3, БС-10/

ЭШФ Т-23483-23484

Намжил Д. **Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл: 2017-2018 оны хичээлийн жил**: Эрдэм шинжилгээний өгүүлэл, Эрдэм шинжилгээний илтгэл, Сонин, сэтгүүл, вэб сайтад өгсөн ярилцлага.- УБ.: Хангай принтинг, 2020.- 160х.



Судлаач Д.Намжилын эрдэм шинжилгээ судалгааны бүтээлийн энэхүү эмхэтгэлд банкны зээлийн хүүг бууруулах, нийгмийн даатгалын сангийн гүйцэтгэх үүрэг үнэт цаасны бүтцийг оновчтой болгох, засгийн газрын өрийн эрсдэл, удирдлагын асуудал, Монголд ЖДҮ хөгжих бизнесийн орчин, төгрөгийн ханшийн уналт, ипотекийн зээлийн хүүг бууруулах зэрэг сэдэв бүхий эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл болон сонин, сэтгүүл, вэб сайтад өгсөн ярилцлагуудыг эмхэтгэсэн байна.

65.261я5

Н 256

/НХУУТ-7, БС-10/

ЭШФ Б-29764-29766

Алтанзаяа Г. **Татварын бүртгэл**: 1-р дэвтэр: Сурах бичиг / Ред. Б.Бадамханд; Хян. Р.Батжаргал; Диз. Ц.Тулга; Эх бэлт. М.Билгүүн.- 11 дэх хэвл.- УБ.: 2020.- 411.- ISBN: 978-99929-4-127-8.

Татварын тухай үндсэн ойлголт, тооцон бүртгэх болон тодорхой төрлийн татваруудын онолын ойлголт, холбогдох хууль эрхзүйн заалт, түүнийг тооцох, нягтлан бодох бүртгэл ба тайлагнах, татварын өмнөх ашиг, татвар ногдуулах орлогын уялдаа, тохируулгын асуудал болон мэдлэг бататгах асуултууд, тест, дасгал, бодлогуудыг оруулсан байна. Энэ ном нь татварын харилцаанд өөрийнхөө хууль ёсны эрх ашигаа хамгаалах, хуулийн дагуу татвараа төлж тайлагнах замаар үүргээ хэрэгжүүлэх арга замд суралцах, түүнийг мэдэхийг хүссэн хэн бүхэнд зориулагдсан болно.



65.261.4я73

A 486

/БС-3/

ЭШФ Т-23494-23495

Батжаргал Б. **Нийгмийн даатгал:** Нийгмийн даатгалын байцаагч, ажилтан, ажил олгогч, даатгуулагч, бичил уурхайчдад зориулсан сурах бичиг, гарын авлага / Ерөн. ред. Д.Далхжав; Хян. Г.Бурмаа.- 2 дахь хэвл.- УБ.: Би Си Ай, 2019.- 271х.



Тус бүтээлд нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын тухай ойлголт, Монгол улсад хэрэгжүүлж ирсэн нийгмийн хамгааллын туршлага, одоо мөрдөж буй хууль тогтоомжийн дагуу иргэн, даатгуулагч танд олгох нийгмийн даатгалын үйлчилгээний талаар, манай улсад болон бусад улсад тохиолдож буй тэтгэврийн даатгалын асуудлууд, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар, нийгмийн хамгааллын томоохон бүрэлдэхүүн болох олон улсын хэлэлцээрийн тухай, тэтгэврийн тогтолцооны тухай болон тэтгэвэр бодох аргачлалууд, бусад улсын тэтгэврийн тогтолцооны талаар өгүүллээ. Мөн нийгмийн даатгал болон тэтгэврийн даатгалтай холбоотой товч толийг гарын авлагад хавсаргажээ.

65.272

Б 335

ЭШФ Т-23400-23402

Лувсандорж П. **Бүтээл туурвилын эмхэтгэл** / Эрхлэн хэвл. Х.Цэвэлмаа; Хэвлэлд бэлт. Б.Сувд.- УБ., 2019.- (МУИС-ийн профессоров эрдмийн өв).- ISBN: 978-9919504021.



МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлж буй “МУИС-ийн профессоров эрдмийн өв” цувралын энэ удаагийн дугаарт Монгол улсын ШУ-ны доктор, профессор академич Пунцагдашийн Лувсандоржийн бүтээлээс толилуулж байна.

65.9(1)

Л 82.

Б.1. Монголын эдийн засгийн шилжилт, хөгжлийн асуудлууд.- 227х.

Монголын эдийн засгийн шилжилт, хөгжлийн асуудлуудтай холбогдолтой монгол, орос, англи хэл дээрх судалгааны ажлуудыг 4 бүлэгт хуваан оруулжээ.

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Т-23296-23300

Б.2. БНМАУ-ын эдийн засгийн хөгжлийн зангилаа асуудлууд, өгүүлэл, нийтлэл.- 299х.

1980 онд хэвлэгдсэн "БНМАУ-ын эдийн засгийн хөгжлийн зангилаа асуудлууд" бүтээл мөн эдийн засгийн шилжилт, мөнгөний бодлого, эдийн засгийн зах зээлийн онолтой холбогдолтой судалгааны 20 гаруй нийтлэл өгүүллүүд тус тус оржээ.


/НХУУТ-5, ГНОФ-5/ ЭШФ Т-23301-23305



Б.3. БНМАУ-ын худалдаа хөгжсөн нь.- 339х.

"БНМАУ-ын дотоод зах зээлийн асуудал" 1968 он, "БНМАУ-ын худалдаа хөгжсөн нь" 1959 он, "БНМАУ-д худалдааны хөгжил" 1968 оны бүтээлүүд тус тус оржээ.

/НХУУТ-5, ГНОФ-5/ ЭШФ Т-23306-23310



УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН

Ханна П. Холболтын газарзүй: Дэлхийн соёл иргэншлийн ирээдүйг зураглахуй / Орч. Д.Үнэнбат, М.Отгонжаргал.- УБ.: Монсудар, 2018.- 427х.- ISBN: 978-99973-1-561-8.

Параг Ханнагийн энэ бүтээл XXI зууны эхэн үеийн геополитикийн тогтворгүй агаад ээдрээт ертөнцөд чиглүүлэгч луужин болохуйц үнэ цэнэтэй бүтээл болжээ. Орчин үеийн дэлхийн дэг журам, Евразийн эдийн засгийг Хятадын ивээл доор нэгтгэх "Нэг бүслүүр, нэг зам" төсөл яагаад АНУ-ын "Азид хүчний тэнцвэрийг хангах" санааг ардаа орхисон хамгийн зөв стратеги болохыг мэдэхийг хүссэн уншигчдад энэ номыг уншихыг зөвлөж байна.

66.4(0)

X 22

/НХУУТ-5, ГНОФ-4/

ЭШФ Т-23440-23442



Үндэсний аюулгүй байдал ба уул уурхай: Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл / Удирд. Н.Жалбажав; Хян. Б.Нэргүй; Эмхт. Б.Нэргүй, Ж.Базарсүрэн, Т.Уранчимэг.- УБ.: Китаб, 2018.- 210х.- ISBN: 978-99978-848-2-4.

БСШУЯ-ны ШУТС-ийн санхүүжилттэйгээр Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2016-2018 онд гүйцэтгэж буй "Эрдэс баялгийн олборлолт ба Үндэсний аюулгүй байдал" сэдэвт суурь судалгааны ажлын хүрээнд хийгдсэн судалгааны үр дүнг хэлэлцсэн эрдэм шинжилгээний хурлын материалыг эмхэтгэн гаргасан байна. Тус хурлаар үндэсний аюулгүй байдлыг хангахад уул уурхай, эрдэс баялаг, ашигт малтмалын холбоотой үйл ажиллагааны үзүүлэх нөлөөллийг тал бүрээс нь шинжлэн авч үзэж, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, нийгэм, эдийн засгийн үр дүнг тооцсон онол практик, арга зүйн чиглэлийн тулгамдсан асуудлуудыг хэлэлцжээ.

66.4(1)+26.34

Y 825

/ХЗС-2/

ЭШФ Б-29713-29715



Эрдэс баялгийн олборлолт ба Үндэсний аюулгүй байдал: Хамтын бүтээл / Ерөн. ред. Н.Жалбажав, Д.Содномдорж; Редакцийн зөвл. Т.Соронзонболд, Б.Содбилэг, Б.Нэргүй.- УБ.: Китаб, 2019.- 236х.- ISBN: 978-99978-794-3-1.



"Эрдэс баялгийн олборлолт ба Үндэсний аюулгүй байдал" суурь судалгааны ажлыг БСШУЯ-ны захиалгат, Шинжлэх ухаан, технологийн санхүүжилтээр ҮБХИС-ийн БХЭШХ-ийн судалгааны төслийн баг 2016-2018 онд хэрэгжүүлсэн байна. Тус хамтын бүтээлд Үндэсний аюулгүй байдалд эрдэс баялгийн олборлолтын нөлөөлөл, эрдэс баялгийн салбарын үзүүлж буй нөлөөлөл, эрдэс баялгийн олборлолтын төрийн зохицуулалт ба үндэсний аюулгүй байдал гэсэн агуулгын хүрээнд судалгаанд суурилсан үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж болон төрөөс баримтлах бодлогын асуудлыг дурдсан байна.


66.4(1)+26.34

Э 739

/НХУУТ-3, ХЗС-4/

ЭШФ Б-29716-29718

Зүүн хойд Азийн аюулгүй байдал ба Солонгосын хойгийн асуудал=Northeast Asian security and Korean peninsula issues: Олон улсын эрдэм шинжилгээний хурал=International conference / Эмхт. Р.Нямдаваа; Хян. Ч.Баттулга; Эх бэлт. Д.Насанжаргал.- УБ.: ҮБХИС-ийн хэвлэх үйлдвэр, 2019.- 235х.- ISBN: 978-9919-22-139-3.



Энэхүү бүтээлд Өмнөд Солонгосын гадаад бодлогын эхний зорилго болох Солонгосын хойгт энх тайван байдлыг бий болгох, тогтооход Азийн бүс нутгийн энх тайван, тогтвортой байдал, бүс нутгийн улс орнуудын хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд зохицуулах боломжийн талаар дурджээ.


66.4(5)

3-925

ЭШФ Т-23471-23473

ТӨР ЭРХ, ХУУЛЬ ЦААЗЫН ШИНЖЛЭХ УХААН

Монтескье Барон де. **Хуулийн амин сүнс=De l'esprit des lois** / Ред. Э.Пүрэвжаргал, П.Сарангарав / Орч. Ред. Б.Дөлгөөн; Орч. Т.Төмөрхүлэг; Эх бэлт. С.Батжаргал.- УБ.: Монсудар, [2019]- 468.- (Монсудар нийгмийн ухаан №5).- ISBN: 978-99973-1-729-2.



Эртний Грек Ромын үеэс XVIII зуун хүртэлх улс төр, нийгэм, эрх зүйн түүхэн хөгжлийг судалж, мөн метафизик, этнологи, соёлын антропологи тусгасны дээр хууль бүрэлдэх шалтгаан хийгээд түүхийн талаарх өөрийн үзэл санаа болон эрх мэдэл хуваах зарчим, улс төрийн эрх чөлөөний баталгааг тодорхойлох, Францын нийгэм-улс төрийн байгуулалыг шүүмжлэх зэрэг асуудлуудын талаар тус бүтээлд тусгажээ.

67(4фр)+66.1

М 77

/НХУУТ-5, ГНОФ-7/

ЭШФ Б-29761-29763

Давааням Г. **Морал хазардын асуудлаас үүдэх толгой компанийн хариуцлага=Liability of parent company based on moral hazard problem.-** УБ.: Адмон принт, 2020.- 168х.- ISBN: 978-9919-22-946-7.



Эл бүтээлд охин компанийн шаардах эрх бүхий этгээдийн өмнө хүлээх толгой компанийн үүрэг хариуцлагын талаар авч үзжээ. Мөн охин компанийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны бохирдол үүсэж буй явдалд толгой компани ямарваа нэгэн байдлаар оролцсон тохиолдолд байгаль орчны бохирдлын улмаас эрх ашиг нь хөндөгдсөн этгээд буюу охин компанийн шаардах эрх бүхий этгээдийн өмнө толгой компани ямар хариуцлага хүлээх эсэхийг хөндөн гаргаснаараа онцлог юм.

67.407

Д 121

ХЗС-21609-21610

Сугар Д. **Өмчийн харилцааны хөгжил, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал** / Ред. Б.Амарсанаа; Эх бэлт. Т.Нарангуа.- УБ.- Мөнхийн үсэг, 2020.- 156х.- ISBN: 978-9919-23-299-3.



Энэхүү номыг хуулийн сургуулийн оюутан, хуулийн төсөл боловсруулах салбарын ажилтан нар болон жирийн уншигч нарт зориулав. Бүтээлд Монгол улсад анх удаа хувийн өмчийг зөвшөөрч, хамгаалсан хууль тогтоомж хэрхэн үүсэж хөгжсөн ба түүнийг үндэслэн хувийн өмч амьдрал дээр бодитойгоор бий болж өөрийн жамаар зам мөрөө гаргасан түүхийг Иргэний эрх зүйн талаас харуулжээ.

67.404.1(1)

С 697

ХЗС-21611-21620

Цогт Ц. **Захиргааны хэргийн шүүх=Administrative court** / Эх бэлт. М.Билгүүн.- УБ.: МУИС пресс, 2019.- 330х.- ISBN: 978-9919-22-619-0.



Зохиолч захиргааны эрх зүйн чиглэлээр 2004 оноос бичсэн өгүүлэл, нийтлэлээ 2016 онд эмхэтгэж гаргасанлээ. Түүнээс хойш шинээр бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, хийсэн судалгаа, үнэлгээ, дүн шинжилгээ зэргийг "Захиргааны хэргийн шүүх" гэсэн нэг сэдвийн хүрээнд багцлан эмхэтгэж Захиргааны хэргийн шүүх байгуулагдсаны 15 жилийн ойд зориулан хэвлүүлсэн энэхүү бүтээлээ мэргэжлийн судлаачид, багш, оюутнуудад зориулан гаргажээ..

67.401

Ц 756

ХЗС-21607-21608

Энхтамир В. **Газрын харилцаа, хөрөнгийн бүртгэл=Land administration, property registration: 300 асуултын хариулт=300 [legal] questions & answers** / Ред. Р.Ганхуяг, Г.Цэцгээ.- 4 дэх хэвл.- УБ., 2019.- 160х.



Энэхүү бүтээлд газрын тухай хууль тогтоомжид зарчмын шинжтэй зарим өөрчлөлт хөдөлгөөн орсныг тусгасны дээр нийгмийн амьдрал өөрчлөгдөн

хөгжих зүй тогтлын дагуу газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн талаар иргэдийн асууж сонирхдог зүйлсийн агуулгад шинэчлэлт гарсан талаар тусгажээ. Мөн энэ 4 дэх удаагийн хэвлэлтэд уншигчид хэрэгтэй мэдээллээ хурдан шуурхай олоход нь зориулан нэр томъёоны цэс шинээр оруулж өгчээ.

67.407

Э 661

ЭШФ Т-23406-23408

ЦЭРГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал: Өнөө ба ирээдүй: Хурлын эмхэтгэл / Хян. Б.Эрдэнэчимэг; Эмхт. Р.Нямдаваа; Эх бэлт. П.Номинцэцэг; Хавтасны диз. Э.Доржханд.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 143х.- ISBN: 978-99978-848-9-3.



Аюулгүй байдлын тухай ерөнхий ойлголт хувьсал өөрчлөлт болон дан ганц цэргийн аюул бус терроризм, хэт даврах, салан тусгаарлах үзэл мөн ундны усны хомсдол, уур амьсгалын өөрчлөлт зэрэг байгаль орчны аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлс болоод хүн төрөлхтний өмнө тулгамдаж буй асуудлуудын талаар эрдэмтэн судлаачдын тавьсан илтгэлүүдийг эмхэтгэн оруулсан болно.

68+66.4

А 961

/ХЗС-2/

ЭШФ Т-23480-23482

Хүч тэнцвэргүй дайн, байлдаан: Судалгаа, шинжилгээ / Ц.Гандорж, Б.Далайбаатар, Ц.Дашзэвэг ба бус.; Ред. Ш.Паламдорж, Ц.Дашзэвэг.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 186х.- ISBN: 978-99978-848-3-1.



Энэхүү бүтээлийг хүн төрөлхтний түүхэнд сүүдэр мэт дагалдсаар ирсэн, улс төрийн бодлогыг өөр хэрэгслээр үргэлжлүүлж байгаагийн илрэл, хүн ард, улс нийгэмд гамшиг таригч нийгмийн онцгой үзэгдэл - дайны мөн чанар, шинж төлөв, хэлбэр агуулгыг цэргийн шинжлэх ухааны үүднээс түүнийг хэрэгжүүлж буй стратеги, операц, тактикийн онол, практик талаас шинжилсэн туршлага, сургамжид тулгуурлан бичжээ.

68

Х 863

/НХУУТ-8/

ЭШФ Т-23499-23501

Батлан хамгаалах стратеги: Онол, арга зүй, шинжилгээний бүтээл / Удирд. Ш.Паламдорж; Ред. Ц.Дашзэвэг; Шинжээчийн дүгнэлт гаргасан Г.Сайханбаяр, О.Үржин, Л.Батцэнгэл, Б.Өлзийхуяг.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 399х.- ISBN: 978-99978-1-454-8.



Тус судалгааны бүтээлд Батлан хамгаалах, зэвсэгт хүчний хөгжлийн бодлого, стратегийн асуудлаар мэргэшсэн судлаач, улс төрчид, цэргийнхэн, магистр, докторын зэрэг хамгаалахаар суралцагчид, орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгаа

хариуцсан албан тушаалтнууд болон сонирхогчдод зориулагдсан энэ бүтээлд батлан хамгаалах стратегийн онол, арга зүй, дэлхийн улс орнуудын туршлага, сургамж, Монгол улсын батлан хамгаалах стратегийн түүхэн хөгжил, өнөөгийн практик хөгжлийн тухай судалгааны өгүүллүүд багтсан байна.

68.4

Б 336

ЭШФ Т-23476

Зэвсэгт хүчний стратеги: Онол, арга зүй, шинжилгээний бүтээл / Удирд. Ш.Паламдорж, Ч.Улаанхүү, Ц.Дашзэвэг ба бус.; Ред. Ц.Дашзэвэг; Шинжээчийн дүгнэлт гаргасан Р.Сүхбат, Б.Өлзийхуяг, Ж.Базарсүрэн, Ч.Баттулга.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 444х.- ISBN: 978-99978-1-455-5.



Батлан хамгаалах, зэвсэгт хүчний хөгжлийн бодлого, стратегийн асуудлаар мэргэшсэн судлаач, улс төрчид, цэргийнхэн, магистр, докторын зэрэг хамгаалахаар суралцагчид, орон нутгийн хамгаалалт, улсын дайчилгаа хариуцсан албан тушаалтнууд сонирхогчдод зориулагдсан тус бүтээлд "Зэвсэгт хүчний стратеги"-ийн хөгжил, чиг хандлага, цэргийн аюулгүй байдлыг хангах стратеги, цэргийн стратегийн үнэлгээний арга зүйн талаар судалгааны өгүүллүүд оржээ.

68.4

З-943

ЭШФ Т-23475

Цэргийн нэр томъёоны тайлбар толь / Ерөн. ред. Ц.Дашзэвэг; Удирд. Ред. Ш.Паламдорж; Хуучин монгол үсэгт хөрв. Д.Болор; Англи хэлний орч. Ц.Гандорж, Ш.Паламдорж, Д.Содномцог; Орос хэлний орч. С.Бэхтулга, Ц.Дашзэвэг, Г.Өлзийбат ба бус.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 702х.- ISBN: 978-99973-70-21-1.



Цэргийн нэр томъёоны тайлбар толь нь Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 35 жилийн хугацаанд туурвисан бүтээлийн нэг болно. Тайлбар толийг бүтээгчид цэргийн нэр томъёо ба хэллэгийг жигдрүүлэх, шинээр оноолт хийхийг гол зорилтоо болгосны дээр улс орныг батлан хамгаалах хүрээний хуульчлагдсан явцуу олон нэр томъёоны учрыг тайлж тайлбарлажээ.

68.4я2

Ц 963

/НХУУТ-2/

ЭШФ Т-23477-23479

Уиллинк Жоко. **Онц хариуцлага=Extreme ownership:** Америкийн тэнгисийн цэргийн seal-үүд хэрхэн манлайлж, ялалтад хүрдэг вэ?=How U.S. Navy SEALs lead and win / Ред. П.Сарангарав; Орч. О.Гомбожав; Орч. Ред. М.Ганцацрал; Эх бэлт. С.Батжаргал.- УБ.: Монсудар, 2019.- 272х.- ISBN: 978-99973-1-792-6.



Энэхүү номонд Америкийн Хуурай замын болон Тэнгисийн явган цэргийн SEAL баг болон мөр зэрэгцэн алба хааж, тулалдаж явсан зэвсэг нэгт ахан дүүсийн тухай өгүүлэхээс гадна багаараа бэрхшээлийг хэрхэн туулж байсан мөн баг гэж

байхгүй бол манлайлал ч байхгүй гэсэн санааг тодотгон харуулсны дээр манлайлалын зарчмуудын талаар тусгажээ.

68.54(7АНУ)+65.290-2

У 255

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23496-23498

СОЁЛ СУДЛАЛ

Наранд ойрхон нутаг Дээд монголчууд=The land close to the sun Haixi Mongols / Ред. Ш.Эрдэнэцэцэг; Номын зөвлөх Б.Бүргэд, Ч.Сэцэнбаатар, Л.Сүхбаатар; Хөрв. Ц.Дэгмүү; Орч. Б.Мөнхтуяа, Б.Болорчимэг, Ч.Чимэддаваа; Номын диз. Э.Энхтулга; Гэрэл зур. Н.Содном.- УБ., 2019.- 158х.: Зур.- (Монгол Улсын Соёл Урлагийн Их Сургууль. Бүжгийн Урлагийн Сургууль).- ISBN: 978-9919-23-1460.



Монголын бүжгийн урлагт тулгамдаж буй асуудлыг судалж, шийдвэрлэх зорилгоор эхлүүлсэн төслийн хүрээнд 7 үе шаттай судалгаа хийгдсэн байна. Энэхүү бүтээлд төслийн багийн 4 дэхь судалгаа болох БНХАУ-ын Хөхнуур мужийн монгол угсаатны соёл, зан заншлын талаар хийсэн судалгааны баримт материал орсон байна. Хөх нуурын цагаан Монгол, баоань, сүбэй Монгол, цастын халх гэхчлэн олон гаралтан хошууд Монголчуудын дуу, хөгжим, бүжиг, ёс заншил, аж төрөх ёсны соёлыг судалж, үзэж сонссоноо баримтжуулан буулгасан энэ бүтээл нь бидний элэг нэгт Дээд Монголчуудынхаа соёл, урлаг, зан заншлын талаар хойч үеийнхэн танин мэдэхэд дөхөм болох буюу.

71.05(545)+63.5

Н 294

ЭШФ Т-23510-23512

ШИНЖЛЭХ УХААН СУДЛАЛ

Acta historica: МУБИС-ийн түүхийн тэнхимийн эрдэм шинжилгээний сэтгүүл: Т. ХХ. Fasciculus 1-14 / Зөвлөлийн дарга Ж.Гэрэлбадрах; Нарийн бичгийн дарга Н.Сүхбаатар; Гишүүд Р.Сабилов, Т.Мэй, Б.Оюунбилиг ба бус.; Эрхл. Ч.Болдбаатар; Эх бэлт. Т.Энхтунгалаг; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 200х.- ISBN: 978-99978-871-6-0.



МУБИС-ийн Түүхийн тэнхимээс эрхлэн гаргадаг эрдэм шинжилгээний сэтгүүлийн энэ дугаарт угсаатан судлал, дундад үеийн түүх, ойрхи үеийн түүхэнд холбогдох судалгааны өгүүлэл, илтгэлүүд оржээ.

72+63.4я5

А 19

/НХУУТ-2/

ЭШФ Т-23412-23413

МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг: Монгол судлал: Боть ХЛП (506) : Хэл шинжлэл, утга зохиол, урлаг судлал / Эрхл. Б.Түвшинтөгс; Зөвлөх Д.Бүрнээ, Д.Галбаатар, Л.Ганчимэг ба бус.; Эх бэлт. Т.Энхтунгалаг.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 165х.- (Монгол Улсын Их

Сургууль. Монгол хэл, хэл шинжлэл болон Утга зохиол, урлаг судлалын тэнхим).- ISSN 1997-1826.



Цувралын энэ дугаарт монгол хэл шинжлэл, бичиг үсэг судлалд холбогдох монгол хэлний түүхэн хэл зүйн зарим зүйл, үгийн сан судлалд холбоотой асуудлыг хөндсөн эрдэм шинжилгээ-судалгааны илтгэл, өгүүлэлүүд оржээ. Мөн сэтгүүлийн “Судалгааны өв” буланд болон Академич Ц.Дамдинсүрэнгийн эрдэм шинжилгээний ажил хийсэн туршлагаас, "Утга зохиол, урлаг судлал" буланд судлаачдын Монголын эртний уран зохиол, монгол уран зохиолын зарим төрөл зүйлийн онцлогийг тодруулсан сонирхолтой өгүүлэлүүд багтсан байна.

72+81я5

М 692.

/ЛавФ-1/

ЭШФ Т-23464-23465

МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг: Монгол судлал: Б. XLIII (520):

Хэл шинжлэл, утга зохиол, урлаг судлал / Эрхл. Б.Түвшинтөгс; Зөвлөх Г.Нандинбилэг, Т.Отгонтуул; Эх бэлт. Т.Энхтунгалаг; Хавтасны загвар Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 227х.- (Монгол Улсын Их Сургууль. Монгол хэл, хэл шинжлэл болон Утга зохиол, урлаг судлалын тэнхим).- ISSN 1997-1826.



"Монгол судлал" эрдэм шинжилгээний цувралын энэ удаагийн дугаарт монгол хэлний ойрын болон холын төрөл хэлнүүдийн харьцуулсан судалгааны зарим зүйл, эх бичиг судлал, хэлний сэтгэлгээний асуудал, монгол ардын аман зохиол болон орчин үеийн уран зохиол, урлаг судлал зэрэгт сэдвийн хүрээнд холбогдох судалгааны илтгэл өгүүлэлүүд оржээ.

72+81я5

М 692

/ЛавФ-1, НХУУТ-2/

ЭШФ Т-23466-23467

Хот байгуулалтын түүхэн үйл явц өнгөрсөн, одоо, ирээдүй: Эрдэм шинжилгээний хурал: Илтгэлийн эмхэтгэл / Эрхл. Б.Пунсалдулам; Хян. Г.Нямсамбуу; Эмхт. З.Алтанцэцэг, Т.Хүрэлжав; Эх бэлт. М.Лхамжав; Хавтасны диз. Д.Хан-Уул; Эх бэлт. С.Нарантуяа.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 384х.



Энэхүү эмхэтгэлд Улаанбаатар хотын үүсэл хөгжлийн түүхээс эхлээд өнөөдрийн хот байгуулалтын үйл явц, монголчууд суурин соёлыг хэрхэн бүтээж шинэ цагийн хотыг байгуулж чадсан ололт амжилт болоод цаашдын тулгамдсан асуудлыг хэлэлцсэн эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүд багтсан байна.

72+85.118(1-2УБ)

Х 505

ЭШФ Т-23409-23411

Шинжлэх ухааны дэвшилтэт технологи: Хөдөө аж ахуй: Онол практикийн бага хурал / Эмхт. Б.Заяа, Б.Хишигсүрэн.- УБ.: Амин Инвест, 2020.- 200х.

Тус бүтээлд Биотехнологийн аргаар мал, амьтны нэмэгдэл тэжээл үйлдвэрлэх инновацийн төслийн хүрээнд хийгдэж буй судалгааны ажлуудын дээжээс танилцуулах, Монголын хөдөө аж ахуйн салбарт цаашид нэвтрүүлж болох, нэвтрүүлэх шаардлагатай шинжлэх ухааны дэвшилтэд технологиудын талаар судлаачдын шинэ санаа, судалгааны үр дүнг хэлэлцсэн эрдэм шинжилгээний илтгэлүүд оржээ.




72+42-2(1)

Ш 659

ЭШФ Т-23403-23405

СЭТГҮҮЛ ЗҮЙ

Зулькафиль М. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд.- УБ.: Удам соёл, 2019.



Сэтгүүл зүйн судалгааны цуврал бүтээлийн 12, 13-р ботид Сэтгүүлчийн ур чадварын тухай, дараагийн 14, 15-р ботид Сэтгүүл зүйн тайлбар толь хэмээх бүтээлүүд багтсан байна. Эхний хоёр ботид сэтгүүлчийн ур чадварын үндсэн ойлголт, бичлэгийн төрөл зүйлийн онол арга зүйг практик жишээ, зөвлөмжөөр баяжуулан тайлбарласан байна. Дараагийн хоёр ботид сэтгүүл зүйн үндсэн ойлголт, онолын нэр томьёо, мэргэжлийн үг хэллэг, мөн сэтгүүл зүйн түүхэнд онцгой байр суурь эзэлдэг ахмад сэтгүүлчдийн тухай товч тайлбарыг цагаан толгойн үсгийн дарааллаар жагсаан оруулжээ.

16-р ботид сэтгүүл зүйн тухай мэдлэгийн үүсэл хөгжил, социосэтгүүл зүйн ойлголт бүтэц, сэтгүүл зүйд хэрэглэгддэг ярилцлага, анкетын санал асуулга, баримт бичиг судлах арга, контент анализ, ажиглалт зэрэг социологийн аргуудын талаар тодорхой жишээ баримт дээр тулгуурлан тайлбарлаж, зарим гадаад нэр томьёоны товч тайлбарыг уншигчдад ойлгомжтой болгох үүднээс хавсралтанд тусгайлан оруулжээ.

76.01

З-80

Б.12. Сэтгүүлчийн ур чадвар-1 / Ред. Л.Норовсүрэн, Т.Баасансүрэн.- 300х.- ISBN: 978-99978-872-8-3.

/НХУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Б-29638-29640

Б.13. Сэтгүүлчийн ур чадвар-2.- 300х.- ISBN: 978-9919-9561-0-3.

/НХУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Б-29641-29643

Б. 14. Сэтгүүл зүйн тайлбар толь-I: А-О / Ред. Л.Норовсүрэн, Б.Болд-Эрдэнэ, З.Серик.- 300х.- ISBN: 978-9919-9561-1-0.

/НХУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Б-29644-29646

Б. 15. Сэтгүүл зүйн тайлбар толь- II: Ө-Я.- 300х.- ISBN: 978-9919-9561-2-7.

/НХУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Б-29647-29649

Б. 16. Сэтгүүл зүйн социологи: Онол, практик, арга зүй.- 2020.- 300х.- ISBN: 978-9919-9561-3-4.

/НХУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Б-29650-29652

ХЭЛ БИЧГИЙН ШИНЖЛЭХ УХААН

Бүргэд Д. **Монголын нууц товчооны хятад галигт монгол хэлний авиаг тэмдэглэсэн зарчмын асуудал=A study on Chinese transcription for the Mongolian sound of the secret history of the Mongols:** Энэхүү бүтээлээ хайрт аав Хэрэйд овогт Га.Данзаны гэгээн дурсгалд зориулбай / Эх бэлт. Э.Жаргалмаа; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ., 2019.- 407х.- ISBN: 978-9919-504-04-5.



Тус бүтээл нь "Монголын нууц товчоон"-ы хятад галигийн судлал, үгийн сангийн судлал, хятад галигийн авианы толь гэсэн 3 үндсэн хэсгээс бүрдэнэ. Судлаач "Монголын нууц товчоон"-ы хятад галигт монгол хэлний авиаг тусгасан зарчим, голчлон барьсан дүрмийг тодруулж, монгол хэлний авиаг галигласан хятад галигийн суурь аман аялгуу нь Бээжин аман аялгуу байсан гэсэн дүгнэлтийг гаргажээ.

81.2М

Б 861

/НХУУТ-7, ГНОФ-8/

ЭШФ Т-23329-23331

Баттогтох Д. **Монгол хэл, уран зохиол, үндэсний бичиг:** Өгүүллүүдийн дээжис.- УБ.: Удам соёл, 2019.- 224х.- ISBN: 978-9919-21-912-7.



Зохиогч тус номондоо өөрийн бичсэн өгүүллүүдээ монгол хэлний сургалт судалгаа, уран зохиолын сургалт судалгаа, үндэсний бичиг үсгийн сургалт судалгаа гэсэн 3 бүлэгт хуваан оруулжээ. Мөн эрдэмтэн багш Чой.Лувсанжав, Д.Төмөр, Х.Сампилдэндэв, Н.Бэгз, М.Базаррагчаа, Л.Дамдинжав, Д.Батсуурь, Д.Нацагдорж, Ч.Жачин, Ч.Дагвадорж нарын тухай бичсэн сонирхолтой хөрөг найрууллууд багтсан байна.

81.2М+83.3(1)

Б 34

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23323-23325

Илийн голын урсгал дагуу оронд хадгалагдаж байгаа тод үсгийн сурвалж бичгийн чуулган: 50 боть: Уйгаржин Монгол бичгээр: / Ерөн. ред. Мянгад Эрдэмт; Ред. Д.Бадам, Х.Сайнбаяр, Д.Төрбат ба бус.- Хөлөнбуйр: Цай Ши хэвлэх, 2015.- (Улсын Эрдмийн Дээд Сургууль. Түүх, хэл судлах газрын Ойрад судлал, Тод судлалын төв).



“И Ли голын урсгал дагуух бүс нутагт хадгалагдаж байгаа тод үсгийн сурвалж бичгийн чуулган”- 50 боть цуврал нь тод үсгийн хамгийн том сурвалж бичгийн бүтээл болсон байна. Тус бүтээлд сурвалж бичгийг цуглуулан эмхтгэгч, ерөнхий редактор, Төвийн Үндэстний Их Сургуулийн профессор Мянгад Эрдэмт гуай 19 жилийн хугацаанд Шиньжянийн Ойрадууд, тэр дундаа Тэнгэр уулын хормой, И Ли голын дээд урсгал дагуу амьдарч байгаа Монгол хүрээ, Дэгс, Нялх, Цавчаал дөрвөн суурингийн ойролцоо хээрийн судалгаа шинжилгээ зохион байгуулсны үр дүнд Ойрадуудын дунд хадгалагдаж байсан тод үсгийн 400 гаруй төрлийн 617 дурсгалт сурвалж бичгийн судалгааг хийсэн байна.

81.2+63.2

И 43

Б.1.- 383х.	ЭШФ Т 23350	Б.26.- 421х.	ЭШФ Т 23375
Б.2.- 395х.	ЭШФ Т 23351	Б.27.- 427х.	ЭШФ Т 23376
Б.3.- 387х.	ЭШФ Т 23352	Б.28.- 402х.	ЭШФ Т 23377
Б.4.- 382х.	ЭШФ Т 23353	Б.29.- 438х.	ЭШФ Т 23378
Б.5.- 384х.	ЭШФ Т 23354	Б.30.- 394х.	ЭШФ Т 23379
Б.6.- 387х.	ЭШФ Т 23355	Б.31.- 419х.	ЭШФ Т 23380
Б.7.- 375х.	ЭШФ Т 23356	Б.32.- 445х.	ЭШФ Т 23381
Б.8.- 383х.	ЭШФ Т 23357	Б.33.- 404х.	ЭШФ Т 23382
Б.9.- 424х.	ЭШФ Т 23358	Б.34.- 402х.	ЭШФ Т 23383
Б.10.- 452х.	ЭШФ Т 23359	Б.35.- 418х.	ЭШФ Т 23384
Б.11.- 434х.	ЭШФ Т 23360	Б.36.- 437х.	ЭШФ Т 23385
Б.12.- 374х.	ЭШФ Т 23361	Б.37.- 412х.	ЭШФ Т 23386
Б.13.- 378х.	ЭШФ Т 23362	Б.38.- 434х.	ЭШФ Т 23387
Б.14.- 442х.	ЭШФ Т 23363	Б.39.- 372х.	ЭШФ Т 23388
Б.15.- 364х.	ЭШФ Т 23364	Б.40.- 440х.	ЭШФ Т 23389
Б.16.- 383х.	ЭШФ Т 23365	Б.41.- 409х.	ЭШФ Т 23390
Б.17.- 400х.	ЭШФ Т 23366	Б.42.- 481х.	ЭШФ Т 23391
Б.18.- 404х.	ЭШФ Т 23367	Б.43.- 437х.	ЭШФ Т 23392
Б.19.- 414х.	ЭШФ Т 23368	Б.44.- 427х.	ЭШФ Т 23393
Б.20.- 389х.	ЭШФ Т 23369	Б.45.- 511х.	ЭШФ Т 23394
Б.21.- 372х.	ЭШФ Т 23370	Б.46.- 385х.	ЭШФ Т 23395
Б.22.- 421х.	ЭШФ Т 23371	Б.47.- 423х.	ЭШФ Т 23396
Б.23.- 390х.	ЭШФ Т 23372	Б.48.- 432х.	ЭШФ Т 23397
Б.24.- 390х.	ЭШФ Т 23373	Б.49.- 413х.	ЭШФ Т 23398
Б.25.- 406х.	ЭШФ Т 23374	Б.50.- 414х.	ЭШФ Т 23399

Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал: 60 жилийн ойд зориулсан цомог / Эмхт. Ц.Шагдарсүрэн; Хян. Д.Заяабаатар, Н.Нарангэрэл; Диз. Ц.Өнөрбаяр.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 216х.



Дэлхийн монголын судлал үүсэж, монголч эрдэмтний анхдугаар их хурал хуран чуулж, олон улсын монголч эрдэмтний байгууллага үүсэн хөгжих үүд хаалга нээгдсэн түүхэн үйл явдлын 60 жилийн ойд зориулсан энэхүү зургийн цомогт Анхдугаар их хурлын түүхэнд холбогдох гэрэл зураг, баримт сэлт, бас бус зүйл болон уг хурлын 30, 50 жилийн ойг хэрхэн тэмдэглэсэн тухай баримтыг нэгэн дор цуглааж эмхэтгэсэн байна.

81.2М

О 295

/НХУУТ-5/

ЭШФ Б-29767-29771

Орчин цагийн монгол хэл.- 5 дахь хэвл.- УБ.: Бит пресс, 2020.- ISBN: 99929-81-23-7.

Энэ номны 1-р ботид монгол хэлний хөгжлийн түүх, монголчуудын бичиг үсгийн түүхийн тойм, авиа зүй, нутгийн аялгуу, зөв бичих зүй, зөв дуудах зүй, найруулга зүйн хэсэг багтсан ба 2-р ботид орчин цагийн монгол хэлний үг зүй, өгүүлбэр зүй, үгийн сангийн судлал, эх судлал гэсэн хэсгийг тус тус оруулж, жишээ баримтаар нотолж өгчээ. Мөн утга зохиолын хэлний халх, өвөр монгол, халимаг, буриадын хэл зүйн бүтээлүүдэд байгаа монгол хэл шинжлэлийн зөрөөтэй нэлээд нэр томьёог хавсаргажээ. Их дээд сургуулийн оюутан суралцагч, магистрант, докторант, монгол хэлний мэргэжилтэн судлаач болон ЕБС-ийн багш нарт зориулагдсан.

81.2М

О-493

Б. 1: Монгол хэлний хөгжлийн түүх, монголчуудын бичиг үсгийн түүхийн тойм; Монгол хэлний авиа зүй; Нутгийн аялгуу судлал; Зөв бичих зүй; Зөв дуудах зүй; Монгол хэлний найруулга зүй / Д.Төмөртоогоо, Г.Цэцэгдарь, Ж.Санжаа ба бус.; Ред. Ц.Өнөрбаян, А.Цог-очир, Ш.Баттөгс.- 200х.

/НХУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Т-23427-23429

Б.2: Монгол хэлний үг зүй; Өгүүлбэр зүй; Үгийн сангийн судлал; Эх судлал / Ц.Өнөрбаян, Л.Жумдаан, Б.Пүрэв-очир ба бус.; Ред. Ц.Өнөрбаян, А.Цог-очир, Л.Жумдаан.- 267х.

/НХУУТ-7, ГНОФ-10/

ЭШФ Т-23430-23432

Поппе Н.Н. **Дөрвөлжин бичиг** / Орч. Х.Лувсанбалдан; Хян. Б.Түвшинтөгс.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 130х.- ISBN: 978-99978-985-9-3.

Энэхүү бүтээлд дөрвөлжин бичгийн түүхийн товч тойм, дөрвөлжин бичгийн цагаан толгойн дуудлага, дөрвөлжин бичгийн зөв бичлэгийн дүрмийн онцлог, хэлний онцлог, дөрвөлжин бичгийн дурсгалыг орчуулгын хамт оруулсны дээр орчуулгад утга зохиол, түүх, хэлний шинжлэлийн тайлбарыг хавсаргажээ.

81.2М

П 586

/НХУУТ-10, ГНОФ-7/

ЭШФ Т-23314-23316

Сүхбаатар О. **Монгол хэлэн дэх самгарди махбод** / Ред. Б.Түвшинтөгс; Эх бэлт. Д.Түвшиндэлгэр, Э.Баярчимэг, Э.Уранжаргал; Хавтасны диз. Г.Төрмөнх.- УБ.: Соёмбо принтинг, 2014.- 160х.- ISBN: 978-99962-2-967-1.

Энэхүү нэг сэдэвт бүтээлд монгол хэлний үгсийн сангийн нэг чухал бүрэлдэхүүнд хамаарах самгарди гаралтай үгс монгол хэлнээ хаагуур, хэдий орж ирсэн, тэдгээрийн агуулгын үндсэн бүрэлдэхүүн, авиа утгазүйн хувьсал өөрчлөлт, зөв дуудах хийгээд зөв бичих зүйд баримтлах үндсэн зарчмын талаар тусгажээ.

81.2-3

С 861

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23320-23322



Шинэбаяр О., Золжаргал Б. **Ур ухаан тэлэх уламжлалт мэргэжлийн үгс** / Ред. Б.Даваажав; Эх бэлт. Ч.Амарзаяа; Хавтасны диз. Ч.Амарзаяа.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 154х.- ISBN 9919-21-579-1.- ISBN 978-9919-21-579-8. Тус номын нэгдүгээр бүлэгт "Нэр томьёоны шинжтэй ардын уламжлалт үгийн өв", Хоёрдугаар бүлэгт "Уламжлалт үгсийн утга учир", "Уламжлалт үгийн утгыг танихуй" хэмээх бүтээлүүд орсон байна. Зохиогчид монгол хэлний үгсийн сангийн нэгэн бүрэлдэхүүн болдог нэр томьёо ба мэргэжлийн үг хоёрын ялгааг онолын үүднээс авч үзсэн бөгөөд монгол соёлын биет өв болох дархны урлал, оёдол, хатгамал, нэхмэл сүлжмэлийн үг хэллэг, тэрэг чарганы нэр томьёо, модон эдлэлийн нэр томьёог бүхэлд нь хамарч, тэдгээрийг "ардын гар урлалын үгс" гэсэн агуулгын хүрээнд судлан нэгтгэжээ.



81.2М

Ш 663

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б-29653-29655

Энхжаргал С. **Монгол хэлцийн тайлбар толь** / Хян.Э.Пүрэвжав.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 208х.- ISBN: 978-9919-22-104-1.



Энэхүү бүтээлд эрдэмтэн судлаачдын сурвалжлан цуглуулж эмхэтгэн хэвлүүлсэн монгол хэлц хэллэг, зүйр цэцэн үгийн эмхэтгэл зэрэг ном бүтээл, толь бичигт орсон хэлц хэллэгийн арвин баялаг сангаас монгол уламжлалт ахуй хийгээд, мал маллагаатай холбоотой өвөрмөц болон хэвшмэл хэллэгүүдийг түүвэрлэн сонгож эмхэтгэсэн байна.

81.2М-4

Э 66

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23311-23313

Эрдэнэсан Д. **Монгол хэлний эх задлалын сорилго-4**: Баримтын ба баримтын бус эх задлал: Шинэчилсэн хөтөлбөрийг баримжаалав: Ерөнхий шалгалтад бэлтгэгчдэд зориулав / Ред. А.Цог-Очир; Эх бэлт. Б.Үүрийнтуяа; Хавтасны диз. Э.Доржханд.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 152х.- ISBN: 978-99978-69-64-7.



Энэхүү номыг ЕБС-ийн монгол хэл, уран зохиолын багш, ахлах ангийн сурагч, мэргэжлийн ангийн оюутан, төрөлх хэлээ бие даан суралцагчдад зориулав. Тус бүтээл нь "Баримтын ба баримтын бус төрөл бүрийн эх задлалын сорилго", "Баримт нотолгоонд суурилан тайлбарлан бичсэн эх дээр ажиллах хэл зүйн сорилууд", "Унших-Бичих үйлийг холбох сорилгууд" гэсэн 3 үндсэн хэсгээс бүрджээ.

81.2М

Э 739

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23326-23328

Эрдэнэсан Д. **Монгол хэлний эхийн онол судалгаа** / Хян. А.Цог-Очир; Эх бэлт. Г.Жавзандулам.- УБ.: Адмон Принт, 2015.- 144х.- ISBN: 978-99973-0-683-8.

Аливаа эхийн утга санаа нь баримтын ба баримтын бус төрөл бүрийн эхийн найруулга болон хэлний янз бүр орчинд өөр өөрийн өнгө аястайгаар илэрдэг өргөн дэлгэр ойлголт тул философи, хэл шинжлэл, сэтгэл судлал, шашин, урлаг, утга зохиол, тайлал зүй (герменевтик) гэх мэт нийгмийн болон танин мэдэхүйн олон шинжлэх ухааны зааг дээрх судалгааны тайлбар шаарддаг нэлээд ярвигтай, сонирхол татсан судлагдахуун юм. МУБИС-ийн НХУС-ийн монгол хэлний тэнхимийн ахлах багш, судлаач Д.Эрдэнэсан нь эхийн тухай үндсэн ойлголт, монгол хэлний эхийн мэдээлэл өргөжин тэлэх арга, монгол хэлний эхэд онцолбор мэдээлэл илрэх арга хэрэглүүрүүдийн талаар нарийвчлан судалсан энэхүү судалгааны бүтээлээ уншигч танаа өргөн барьжээ.



81.2М-5

Э 739

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Б-29656-29658

Эсээ: уншья, сурья, бичье / Эмхт. А.Энхнаран; Эх бэлт. Т.Түвшинжаргал; Диз. Б.Эрдэнэбулган.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 174х.- ISBN: 999784918-3.



БСШУЯ-аас 2018 онд зарласан "Багшийн хөгжил-сурах бичиг-сургалтын хэрэглэгдэхүүний хэрэглээ" сэдвээр эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаан зарлаж "Сурагчдын эсээ бичих чадварыг сурах бичгээр дэмжих нь" сэдэвт илтгэл хэлэлцүүлсэн. Тус хэлэлцүүлгийн үр дүнд сурагчдад гарын авлага болохуйц энэхүү "Эсээ: уншья, сурья, бичье" хэмээх сургалт арга зүйн эмхэтгэлийг бүтээн толилууулж байна.


81.2М+74

Э 879

/НХУУТ-7/

ЭШФ Т-23344-23346

Өнөрцэцэг Н. **Монгол хэлний хэлцийн утга, хэрэглээ англи, солонгос хэлэнд дүйх хэллэг**: Монгол, уйгаржин, англи, солонгос хэл дээр / Хян. Л.Ганчимэг, Ким Гисонь, Д.Батцэцэг; Зур. Б.Нэмэхням.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 210х.- ISBN: 978-9919-22-273-4.



Энэхүү номонд монгол хэлний 100 хэлцийг сонгон авч хэлц бүрийг сонирхолтойгоор ойлгуулах зорилгоор шууд утгыг зургаар илэрхийлж, түүний доор утгын товч тайлбарыг тусгажээ. Үүнчлэн хэлц үгийг ямар нөхцөлд хэрхэн хэрэглэхийг тодруулах үүднээс монгол хэлээрх ном зохиолоос ишлэн сийрүүлж, бататгал болгон харилцан яриаг зохион оруулж мөн хэлц үгнүүдийг уламжлалт монгол бичгээр хавсарган, гадаад хэл сурч буй монгол залуус, монгол хэлийг гүнзгийрүүлэн суралцагчдад зориулан англи, солонгос хэлэнд дүйх хэллэгийг хамтад нь оруулж өгчээ.

81.2М-3

Ө 824

/НХУУТ-5/

ЭШФ Б-29689-29691

Манж, хятад, монгол, тод үсэг хавсарсан толь бичиг=Terraglot thermal dictionary in Manchu, Chinese, Mongolian and clear script / Эрхлэн хэвл. Т.Отгонтуул, Б.Аагнеш;

Судалгааны баг М.Баярсайхан, Б.Аагнеш, Д.Заяабаатар ба бус.; Эх бэлт. Э.Уранбилэг; Хавтасны диз. Б.Эрдэнэбулган.- УБ., 2020.- 456х.- ISBN: 978-9919-504-13-7.



МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлж буй энэхүү толь бичиг нь “Хааны бичсэн манж үгний толь бичиг”-ийн нэг адил зүйл хуваасан толь аж. Зохиогч, зохиосон цаг хугацаа, зохиолын нэр тодорхойгүй тус толь бичиг Унгар улсын Шинжлэх ухааны академид хадгалагдаж байгаа бөгөөд Монгол судлалын хүрээлэн нь байгууллагын албан ёсны зөвшөөрлийн дагуу анх удаа нийтийн хүртээл болгон уншигч та бүхэнд толилуулж байна.

81.2-4

М 221

/НХУУТ-10, ГНОФ-5/

ЭШФ Т-23502-23506

Пүрэвжав Э. **Монгол хэлний хэм хэмжээ судлал=Studies on linguistic norms of Mongolian language** / Эрхлэн хэвл. Д.Заяабаатар; Эх бэлт. Э.Уранбилэг.- УБ.: 2020.- 264х.- ISBN: 978-9919-23-262-7.



Монгол хэлний хэм хэмжээ судлал, хэлний дуудлагын хэм хэмжээ, үг хэрэглээний хэм хэмжээ, хэл зүйн хэм хэмжээний талаар тусгасны дээр орчин цагийн монгол хэлний авиа зүй, үгийн сан, хэл зүйн түвшин ба сүүлийн 100 жилийн дотор монгол хэл шинжлэлийн чиглэлээр хэвлэгдэж гарсан ном, өгүүллийн жишээ баримтууд, он цагийн нугачаанд байнга хувиран өөрчлөгдөж байдаг хамгийн эртний нийгмийн үзэгдэл, хэлний зөв болоод буруу өөрчлөлт хувиралтын талаар хийсэн шинжилгээ судалгааг оруулжээ.

81.2М

П 915

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23485-23487

Япон хэл I / Ц.Дэлгэрэхцэцэг, Э.Тогтуун, П.Энхжаргал ба бус.; Ред. С.Долгор, Мачико Хишикава.- УБ.: МУИС пресс, 2020.- 294х.



Энэхүү сурах бичигт япон хэлний боловсролын JF стандартын үзэл баримтлалд тулгуурласан “Суралцагчид өөрийгөө танилцуулах, миний нэг өдөр, амралтын өдөр, сургуулийн амьдрал, унаа хоол, юм худалдан авах, эрүүл мэнд, дуртай зүйл, төрсөн өдөр, аялал зугаалга” гэх түгээмэл сэдвийн хүрээнд сонсох, унших, бичих болон харилцан ярих анхан шатны мэдлэг чадвар олгох агуулгыг багтаасан байна. Түүнчлэн дээрхи чадварыг эзэмшихэд шаардагдах цагаан толгойн хирагана, катакана 96 үсгийн дуудлага, бичлэг, нийлэмж, тэмдэглэгээ, 130 орчим ханз үсгийг унших, бичих, хэрэглэх арга, 900 орчим өдөр тутмын хэрэглээний үг хэллэг, мөн хэл зүйн үндсэн ойлголтууд болох нэр үг, тэмдэг нэр, үйл үгийн хувилал, энгийн болон нийлмэл өгүүлбэрийн бүтцийг энгийн ойлгомжтой жишээгээр баяжуулан тайлбарлажээ.

81.2Яп-923

Я 701

/НХУУТ-17, ГНОФ-30/

ЭШФ Т-23283-23285

УТГА ЗОХИОЛ СУДЛАЛ

Ганбат Б. **Бажуудайн Ганбатын 70 насны ойд: 5 боть / Хэвлэлд бэлтгэсэн Н.Юмсүрэн, Г.Туяа, Г.Элбэгсайхан.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- (Монголын шилдэг нийтлэл эрдэм шинжилгээ, судалгааны төв. Монголын Зохиолчдын Эвлэлийн үргэлжилсэн үгийн зохиолын төв).**

Монголын орчин үеийн утга зохиолын нэрт судлаач, шүүмжлэгч Бажуудайн Ганбатын бичсэн утга зохиолын судлал шүүмжлэл нь баримт нотолгоо хийгээд үнэлгээ гаргалгаагаараа гайхамшигтай, яруухан хэл хэллэг, утга найруулгатай билээ. Түүний бүтээлийн энэхүү 5 ботид судлаачийн бичсэн нийтлэлүүд, өгүүллэг, тууж мөн Б.Ганбатын Ч.Лодойдамбын амьдрал, уран бүтээл болон нэрт зохиолчийн урлах арга барицыг судлан шинжилсэн шүүмж судлалын бүтээлийг эмхлэн оруулсан ба төгсгөлийн 5-р ботид Б.Ганбат агсны тухай түүний үзэг нэгт нөхөд болон гэр бүл үр хүүхдүүдийнх нь бичсэн дурсамж тэмдэглэл, мөн судлаачийн зарим төгсөөгүй номын бичлэгүүдийг оруулсан байна.

83.3(1)

Г 21

Б.1: Эх ба эцэг: Нийтлэлийн эмхэтгэл / Хян. Т.Баасансүрэн.- 432х.- ISBN: 978-9919-22-243-7.

ЭШФ Т 23414-23415

Б.2: Замын хүзүү урт: Өгүүллэг, туужийн эмхэтгэл / Хян. Ц.Өнөрбаян.- 408х.- ISBN: 978-9919-22-244-4.

ЭШФ Т 23416-23417

Б.3: Утга зохиолын шүүмжлэл, судлал / Хян. Ш.Цэнд-Аюуш.- 376х.- ISBN: 978-9919-22-245-1.

ЭШФ Т 23418-23419

Б.4: Монголын сонгодог зохиолч Чадраабалын Лодойдамба: Амьдрал, уран бүтээл / Хян. Л.Түдэв, Ц.Мөнх.- 2 дахь хэвл.- 384х.- ISBN: 978-9919-22-246-8.

ЭШФ Т 23420-23421

Б.5: Уул шиг түшигтэй нөхөр минь / Хян. Т.Баасансүрэн.- 2 дахь хэвл.- 344х.- ISBN: 978-9919-22-247-5.

ЭШФ Т 23422-23423

Мөнхтөр Л. **Ярьдаг роман буюу Базарын Цэдэндамба /** Ред. Ж.Эрдэнэ-Уул; Диз. М.Мөнхтүшиг.- УБ.: Тоонот принт, 2019.- 230х.- ISBN: 978-9919-22-227-7.

Монголын радио гэдэг их өргөөнөөс сонсогч олонтойгоо агаарын цэнхэр долгионоор "ах дүү" шиг танил болсон "Монголын радиогийн бүдүүн дуут" хэмээх Базарын Цэдэндамба агсны шавь Хэл бичгийн ухааны доктор Лханаагийн Мөнхтөр багшийнхаа тухай түүний олон сайхан яруу найргийн ном бүтээж,



роман туурвиж, дууль хайлж, дууны шүлэг бичиж, орчуулга хийж, радиогоор ярьж... оюун сэтгэлийнхээ орон зайд үргэлж дүүрэн ачаатай явсан багшийгаа мөнхлөн үлдээх хүслээр энэхүү дурсамжийн номыг бүтээж, уншигч таны оюуны халуун алган дээр дэлгэн тавьж буй заа.

83.3(1)

М 816

ЭШФ Б-29659-29661

Очир А. **Д.Нацагдорж: Амьдрал, үйлс** / Ред. Б.Түвшинтөгс; Эх бэлт. С.Амарзаяа; Хавтасны диз. Р.Батболд.- 2 дахь хэвл.- УБ.: Соёмбо принтинг, 2016.- 216х.- ISBN: 978-99973-79-09-2.



Энэхүү бүтээлд Д.Нацагдоржийн нийгэм, улс төр, соёл, шинжлэх ухааны салбарт ажилласан он жилүүд, оруулсан гавьяа зүтгэл хийгээд амьдралынх нь талаар архивын баримт, түүх, эрдэм шинжилгээний тулгуур бичгүүдэд үндэслэн тодруулан гаргахыг зорьсон болно. Мөн Д.Нацагдорж нь Монголын ойрхи цагийн түүхэнд хамаарах боловч түүний амьдрал, бүтээлд тодорхойгүй зүйлүүд байсаар байна. Иймд энэ бүтээл уншигч та бүхэнд Д.Нацагдоржийн амьдрал, олон талт үйл ажиллагаа, уран бүтээлийн талаар илүү тодорхой тусгажээ.

83.3(1)

О-605

/НХУУТ-7, ГНОФ-5/

ЭШФ Т-23317-23319

Хүү Д. **Хүүхдийн зохиолын судалгаа: Б.3: Тайлбар зохиол, судалгаа, исээ тэмдэглэл, хөрөг ярилцлага, уялга үг** / Ред. А.Мөнх-Очир; Эмхт. Х.Отгонжаргал.- УБ.: Адмон принт, 2020.- 538х.- ISBN: 978-9919-21-852-2.



Зохиолч уран бүтээлчдийн дотны зөвлөх, шүүмжлэгч, судлаач, багш Д.Хүү нь Монголын хүүхдийн уран зохиолын төрх, өнгө, аяс, дүрслэлийг судлан шинжилж дүгнэсэн олон ном бүтээл туурвисан байна. Түүний энэхүү бүтээлд Монголын хүүхдийн зохиолд хийсэн судалгаа, шүүмж, асуудал дэвшүүлсэн тайлбар, исээ тэмдэглэл, таталбар бичээс, зохиолчдын тухай дурсамж дурдатгалууд оржээ.

83.8(1)

Х 851

/НХУУТ-3/

ЭШФ Б-29692-29693

УРАН ЗОХИОЛ

Мөнгөнхөлөг Б. **Хос дэвтэр Б.2: Бас бус...** / Ред. Я.Баатар.- УБ.: Соёмбо принтинг, 2017.- 133х.- ISBN: 978-99978-0-795-3.




Зохиолч Б.Мөнххөлөгийн "Уран зохионгуйн ертөнцөөр..." хэмээх номны үргэлжлэл болох энэхүү бүтээлд түүний зохиосон шүлэг, туурь, бичил өгүүллэг болон мөн багш нарынхаа тухай бичсэн хөрөг, дурсамж, тэмдэглэлүүд оржээ. Номны төгсгөлд бүтээлийн жагсаалтаа хавсаргасан байна.

84(1)

М 812

ЭШФ Б-29694-29696

Испани өгүүллэг, тууж / Ред. Б.Батцэцэг, П.Сарангарав; Орч. Ред. Б.Эрдэнэчимэг, Б.Пүрэвсүрэн, Г.Сугиррагчаа ба бус.; Эх бэлт. Э.Энэрэл.- УБ.: Монсудар, 2019.- 467х.- (Дэлхийн шилмэл өгүүллэг: 3-р дэвтэр).- ISBN: 978-99973-1-616-5.



XX зууны сүүлийн гучин жилд испани өгүүллэг шинэ үе шатанд дэвшиж, сэдэв, хүрээ нь өргөжих хандлагатай болжээ. Сэтгэл зүйн өгүүллэг, мөрдөгч, гэмт хэргийн, уран зөгнөлт, утга уянгын болон бичил өгүүллэг гэх мэтээр өргөн хүрээг хамарчээ. Энэхүү эмхтгэлд XIX, XX зууны Испанийн уран зохиолын шилдэг төлөөлөгчдийн гучин зургаан өгүүллэг багтжээ.


84(4Исп)-44

И 88

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Б-29746-29748

Ишигуро Казүо. Намайг бүү явуулаач=Never let me go / Ред. Ж.Хишигжаргал, П.Сарангарав / Орч. ред. Н.Жавхлан; Орч. Б.Байгалмаа.- УБ.: Монсудар, 2019.- 342х.- ISBN: 978-99973-1-783-4.



Казүо Ишигуро энэхүү романдаа өнөөгийн Англи орноос тэс өөр хар бараан орчинд өсөн торниж, насанд хүрч буй хэсэг сурагчийн амьдралыг өдгөө гучин нэгэн настай Кэт. Ш-ийн дүрээр өгүүлжээ. Гаднаасаа амар жимэр, аз жаргалтай мэт харагдах Хейлшим сургуульд өнгөрүүлсэн Кэтийн хүүхэд нас, мөн түүнийг болон дотны нөхдийг нь тосон хүлээж буй гадаад ертөнц дэх хувь тавилантайгаа хэрхэн эвлэрэх тухай зохиолд хүүрнэжээ. Хайр дурлал, нөхөрлөл, дурсамжийн энэхүү түүхэнд хүний амьдралын эмзэг, хэврэг чанар нэвт шингэжээ.

84(6Анг)-44

И 975

НХУУТ-5, ГНОФ-4

ЭШФ Б-29754-29756

Камю Альбер. Этгээд хүн / Ред. Ө.Уянга, П.Сарангарав; Орч. Т.Төмөрхүлэг; Эх бэлт. С.Батжаргал.- УБ.: Монсудар, 2019.- 160х.- (Дэлхийн сонгодог утга зохиолын чуулган №30).- ISBN: 978-99973-1-778-0.



Энэхүү роман нь тухайн цаг үеийнхээ оюун санааг уран зохиолын аргаар гарамгай илтгэн харуулсны дээр Камю хоёр зүйлийг нэг дор багтаасан нь уг зохиолын онцлог юм. Нэгдүгээрт Хемингуэй, Фолкнер болон тухайн үеийн Америкийн бусад зохиолчийг санагдуулахаар илүү дутуу зүйлгүй товч цомхон, хоёрдугаарт зохиолыг утга санааны хувьд Европын уламжлалтай уялдуулж өгчээ. Уг бүтээлд зохиолын би хүүрнэгч гуч гарч яваа залуу эр болох Мерсо, түүнтэй сүй тавьсан Мари Кардона гэгч бүсгүйн талаар дурдахын сацуу зохиолын гол баатар хэрэгт холбогдож шоронд өнгөрүүлж буй өдөр хоногуудын талаар өгүүлнэ.

84(6Алж)-44

К 18

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б-29719-29721

Кензабүро О. **Хувийн асуудал** / Япон хэлнээс орч. Ц.Онон; Орч. Ред. М.Ганцацрал; Ред. Ж.Хишигжаргал, П.Сарангарав; Эх бэлт. С.Батжаргал.- УБ.: Монсудар, 2019.- 210х.- ISBN: 978-99973-1-686-8.



Оэ Кензабүрогийн энэ бүтээлд ганц хүний бодрол, эргэцүүлэлийг маш нарийн хүүрнэн өгүүлэхээс гадна ердөө хэдхэн хоногийн үйл явдлыг ч хэдэн зуун хуудас роман болгон дүрслэн үзүүлэх Япон зохиол яахын аргагүй амттай санагддаг. Тэр дундаа Хувийн асуудал роман ихээхэн сонирхол татсаны гол шалтгаан нь ёс суртахуун, нэр хүнд, өөрийн үнэлэмжээ ямагт дээгүүр тавьдаг Японы соёлын хэм хэмжээг эвдэн, харин хувь хүний сул дорой, аминч, чөтгөрлөг талыг ил гаргахыг зорьсонд буй.


84(5Яп)

К 354

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б-29680-29682

Конрад Жозеф **Харанхуйн зүрх=Heart of darkness** / Ред. Ш.Баярмагнай, Д.Очирмаа; Орч. Н.Ганбат; Орч. Ред. Г.Сугиррагчаа.- УБ.: Монсудар, 2019.- 206х.- (Утга зохиол судлал №28).- ISBN: 978-99973-1-750-6.



Конрад бол Чөлөөт Конго улсын үнэн бодит дүр зургийг харуулах зохиол бичсэн анхдагчдын нэг юм. Энэхүү зохиол нь колончлолыг эсэргүүцэж, тухайн цаг үед ноёрхож байсан Европын империализм ба колончлолын үнэн мөн чанарыг ойлгоход хувь нэмэр оруулсан шүүмжлэлт бүтээл юм. Конрадын хамгийн алдартай, хамгийн их тайлал, тайлбар, маргаан дагуулсан тус бүтээл нь анх удаагаа монгол хэлнээ орчуулагдан уншигч таны гар дээр хүрч байна.

84(6Анг)-44

К 64

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б-29722-29724

Крахт Кристиан **Эзэнт гүрэн=Imperium** / Ред. Б.Батцэцэг, Д.Очирмаа; Орч. Б.Ундрах; Орч. Ред. Г.Сугиррагчаа; Эх бэлт. Э.Энэрэл.- УБ.: Монсудар, 2019.- 226х.- ISBN: 978-99973-1-549-6.



Кристиан Крахт бол Швейцарын хамгийн алдартай зохиолчдын нэг бөгөөд ёгтлолт бүтээлүүд нь уран зохиолын салбарт онцгой байр суурь эзэлдэг. Эзэнт гүрэн хэмээх энэхүү зохиол нь түүнд олон улсын тавцанд гарах боломжийг нээн өгч, өдгөө 25 хэлнээ орчуулагдан гараад байгаа юм байна. Зохиолын гол баатар нь Аугуст Энгельхардт нь бодит хүн бөгөөд Кристиан Крахт түүний эмгэнэлтэй хувь заяаг уран зохиолын аргаар баяжуулж энэхүү сургамжит зохиолоо туурвисан байна.

84(4Шве)-44

К 788

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б-29725-29727

Кээлманн Даниел **Дэлхийг хэмжсэн нь=Die vermessung der welt** / Ред. Ж.Хишигжаргал, Д.Очирмаа; Орч. Н.Лувсандорж, Г.Ариунцэцэг; Эх бэлт. С.Батжаргал.- УБ.: Монсудар, 2019.- 246х.- ISBN: 978-99973-1-782-7.

Энэхүү романд Европ дахь соён гэгээрлийн үеийн сод болсон хоёр герман эрдэмтний тухай өгүүлдэг. Тэдний нэг нь байгаль судлаач, газар орныг нээгч Александер фон Хумбольдт (1769-1859), нөгөөх нь түүнээс найман насаар дүү, математикч газар хэмжигч Карл Фридрих Гаусс (1777-1855) бөгөөд тэднийг хувь хүн талаас нь гэр бүл, найз нөхөд, охид бүсгүйчүүдтэй ямар харилцаатай байсныг нь илчилж, хил заагийг нь харуулсан сэтгэл хөдөлгөм сонирхолтой түүхийг өгүүлжээ.



84(4Гер)-44

К 98

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ-Б-29731-29733

Лий Харпер Гургалдайг хөнөөхүй=**To kill a mockingbird** / Ред. Ж.Хишигжаргал, П.Сарангарав; Орч. Ред. Н.Жавхлан; Орч. Г.Сугиррагчаа; Эх бэлт. С.Батжаргал.- УБ.: Монсудар, 2018.- 456х.- ISBN: 978-99973-1-542-7.



Өмнөдийн нэгэн жижиг хотод өнгөрүүлсэн хүүхэд насны дотоод сэтгэлийн хямралын тухай өгүүлсэн бүтээл төдийгүй 1960 онд хэвлэгдсэн даруйдаа шилдэг борлуулалттай номоор шалгарчээ. Мөн уг бүтээл нь энэрэнгүй, сэтгэл хөдлөм, хурц өгүүлэмжтэй уншигчдыг хүмүүний зан төлвийн уг үндэс болох гэнэн сэтгэл ба харгис хатуу чанар, хайр ба үзэн ядалт, хошигнол ба шаналал руу хөтөлнө. Алабама муж улсаас гаралтай залуу бүсгүйн бичсэн энэ роман дэлхийн бүх томоохон хэлнээ орчуулагдаж олон сая уншигчийн хүртээл болжээ.

84(7АНУ)-44

Л 55

/НХУУТ-5, ГНОФ-4/

ЭШФ Б-29751-29753

Мелле Томас Нуруун дээрх ертөнц=**Die welt im rucken** / Ред. Б.Одончимэг, П.Сарангарав; Орч. Г.Ариунцэцэг; Орч. Ред. Б.Ундрах.- УБ.: Монсудар, 2019.- 400х.- ISBN: 978-99973-1-546-5.



Энэхүү бүтээл нь сэтгэлийн хөөрөл, гутралын "хоёр туйлт эмгэг"-ээр олон жилийн турш шаналж буй сэтгэцийн эмгэгтэй хүний амьдрал, бодол санаа, өвчний түүхийг дүрсэлсэн намтар зохиол бөгөөд зохиогч өөртөө тохиолдсон явдал хийгээд эрүүл мэнд нь удаан хугацааны туршид хэрхэн сайжирч байгаа болон өвчтөний сэтгэл зүйн дотоод ертөнцөд болж байгаа үйл явцыг сонирхолтой хүүрнэн өгүүлжээ.

84(4Гер)

М 418

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б-29734-29736

Михаэлидес А. Хэлгүй өвчтөн=**The silent patent**: Эцэг, эхдээ зориулав / Англи хэлнээс орч. А.Оюунзул; Ред. Г.Сугиррагчаа; Д.Сарангарав; Эх бэлт. Э.Энэрэл.- УБ.: Мон судар, 2019.- 360х.- ISBN: 978-99973-1-751-3



Сэтгэл зүйн триллер төрлийн шилдэг зохиолын тоонд зүй ёсоор тооцогдож буй "Хэлгүй өвчтөн" зохиол нь нөхрөө буудаж хороосноос хойш нэг ч үг дуугарахаа больсон зураач бүсгүй Алиша Беренсоны ээдрээт түүхийг тун сонирхолтой өгүүлнэ. Тэр эмэгтэй нөхрөө хөнөөхдөө 33 настай байжээ. Үүнийг уншихад

танд ямар ч эргэлзээ төрөхгүй ч хэргийн учир зангилаа санаанд оромгүй ээдрээтэй өрнөнө. “...Би одоо ойлгосон. Би хэзээ ч аюулгүй байхгүй. Хэзээ ч хайрлуулахгүй. Бүх л итгэл найдвар, хүсэл мөрөөдөл минь үгүй болж, юу ч үлдээгүй, юу ч. Аавын минь зөв байжээ. Би амьдрах эрхгүй. Би юу ч биш. Габриель намайг ингэж орхисон юм. Ийм л зүйл болсон. Би Габриелийг алаагүй. Тэр намайг алсан. Би зөвхөн л гох дарсан...”

84(4ИхБр)

М 632

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б-29674-29676

Набоков В. **Лолита**: Роман / Орч. Б.Бүдболд; Ред. Н.Жавхлан, Ш.Баярмагнай, П.Сарангарав.- УБ.: Мон судар, 2019.- 463х.- ISBN: 978-999736-1-762-9.



Хижээл насны нэгэн эр 12 настай бяцхан охинд дурласнаар өөрийгөө захирах жолоодлогогүй болж буй үйл явдлаар өрнөх энэхүү романыг зарим судлаачид сэтгэцийн эмгэгийн тухай роман гэж үзэх ч байдаг. Юутай ч Лолитагаас өөр ямар ч хайр дурлалын зохиол уншигч авхай танд магадгүй жигшил зэвүүцэл төрүүлэхийн хэрээр шимтэн унших хүслийг өдөөх буй заа.


84(7АНУ)-44

Н 126

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б-29686-29688

Сангү И. **Сүгхян бүсгүйн домог** / Солонгос хэлнээс орч. И.Анна, Д.Уугантуяа; Ред. Х.Саруул-Эрдэнэ, М.Ганцацрал, Д.Очирмаа; Эх бэлт. С.Батжаргал.- УБ.: Мон судар, 2019.- 247х.- ISBN: 978-99973-1-763-6.



“Сүгхян бүсгүйн домог” нь Өмнөд Солонгос улсын олон түмний хүртээл болсон эртний зохиолуудын нэг юм. Энэ зохиол нь ид шидийн уран сэтгэмжит үйл явдлын нарийн өрнөлөөр дамжуулан Жусоны хожуу үеийн нийгэм, ард олны сэтгэлзүй, амьдралын жинхэнэ байдлыг үнэн бодитоор тусгасан өвөрмөц өнгө аясыг илэрхийлэх бөгөөд үймээн самуунаар эцэг эхээсээ хагацсан гол дүрийн Сүгхян охины зовлон шаналал, Сүгхян болон И Соний ээдрээт учрал-гэрлэлт, Сүгхян бүсгүйн эцэг эхтэйгээ эргэж уулзсан түүх, аршийн оронд хийсэн И Соний аялал зэрэг нь зохиолын ерөнхий агуулгыг бүрдүүлнэ. Гэвч энэхүү зохиолын хамгийн гол агуулга нь Сүгхяны зовлон зүдгүүр юм...


84(5Сол)

С 293

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б-29677-29679

Солонгос өгүүллэг, тууж / Ред. М.Ганцацрал, Ш.Баярмагнай, П.Сарангарав; Орч. М.Амартайван; Эх бэлт. С.Батжаргал.- УБ.: Монсудар, 2019.- 342х.- (Дэлхийн шилмэл өгүүллэгийн түүвэр).- ISBN: 978-99973-1-777-3.



Солонгосын зохиолчдын шилдэг төлөөлөл болсон арван хоёр зохиолчийн шилмэл бүтээлүүдийг оруулсан байна. Уг түүвэрт багтсан бүтээлүүд нь агуулгын хувьд Солонгос орны нийгмийн ороо бусгаа тогтворгүй үеийн бараг наян жилийн түүхийн тод тусгал болсон гэж үздэг.

84(5CoA)-44

C 556

/НХУУТ-5, ГНОФ-4/

ЭШФ Б-29737-29739

Хасбилэг Б. **Наран малгайтай нисгэл** / Ред. Б.Батжаргал; Эх бэлт. Ц.Амартүвшин; Хавтасны зур. Ж.Бадмаанямбуу.- УБ.: Бэмби сан, 2019.- 136х.- ISBN: 978-99978-707-9-7.



Өвөр монголын яруу найрагч Б.Хасбилэг нь Баруун онгодуудын уугуул бөгөөд Баарин нутгийн хүн аж. Зохиогчийн энэхүү бүтээл нь сургуулийн бага насныханд зориулагдсан төдийгүй хүүхдийн сонин сэтгэхүй, уран санааг олж нээн тэдний хүсэл тэмүүлэл, хязгааргүй их мөрөөдөлд нь тургуурлан бичжээ. Энэхүү шүлгийн түүвэрт нь 50 гаруй шүлэг багтжээ.

84(545)-5

X 263

ЭШФ Б-29740-29742

Этвүүд Маргарет. **Шивэгчний үлгэр=The handmaid's tale** / Ред. Б.Одончимэг, П.Сарангарав; Орч. Ред. Б.Шижирээ; Орч. Л.Гэрэлмаа; Эх бэлт. С.Батжаргал.- УБ.: Монсудар, 2019.- 419х.- ISBN: 978-99973-1-595-3.



Энэхүү зохиол нь "дистопи роман" хэмээх төрөлд хамаарна. Дистопи романд үйл явдал нь ойрын ирээдүйд болж, зохиолд өрнөж буй тэр ертөнцөд нийгмийн дэг журам сөрөг тал руугаа өөрчлөгдөж буй тухай ихэвчлэн өгүүлдэг. Уг роман нь хөгжилтэй, тааварлашгүй, аймшигтай, цаанаа л үнэмшилтэй, айхтар гүн ёгтлол, нухацтай сануулга бүхий бүтээл төдийгүй өнөөгийн олон чиг хандлагыг авч үзэн, эдгээр нь эцэстээ ямар аймшигтай үр дүнд хүргэж болох, бидний амьдралын хэв маяг хаашаа чиглэж буйг харуулахын сацуу улс төр, сексийн бараан холбоо сүлбээг ил тод харуулжээ.

84(7Кан)-44

Э 90

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б-29743-29745

УРЛАГ СУДЛАЛ

Батжаргал Б. **Америкт учирсан урансайхан: Сэтгүүл зүйн туршиц** / Хян. Бэйд Дэвид, Ж.Оюунцэцэг, М.Пүрэвбадам ба бус.- 3 дахь хэвл.- УБ.: ХБКоллежийн хэвлэх, 2013.- 248х.- ISBN: 978-1-4675-3679-0.




Зохиогч энэ номондоо алс холын Америкт Монголын урлаг соёлыг түгээн дэлгэрүүлж, хөгжүүлж байгаа уран бүтээлчид болон тэдний уран бүтээлийн талаар өөрт төрсөн сэтгэгдэл бодролоо дүгнэн буулгасан ажээ. Номын агуулгыг мэдээ нийтлэл, эсээ тэмдэглэл, хөрөг шүүмж, фельетон асуудалт өгүүлэл, эрдэм-судалгааны өгүүлэл хэмээн урлагийн сэтгүүлзүйн бичлэгийн үндсэн төрөл жанруудад хуваасан байна.

85(1)

Б 335

ЭШФ Б-29712

Монголын урлагийн түүхээс: Урлаг судлалын хичээлийн гарын авлага / Хян. Л.Хэрлэн.- УБ.: Удам соёл, 2019.- 424х.- (МУИС. ШУС. ХУС).- ISBN: 978-9919-23-331-0.



МУИС-ийн Урлаг судлалын хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудын энэхүү хамтын бүтээлд Монгол бүжиг, дуу, кино, музей, театрын урлаг, уран барилга, хөшөө дурсгал, баримал, уран зураг, цирк зэрэг урлагийн бүх салбарын уран бүтээл, тэдгээрийн үүсэл хөгжил, судлагдахууныг тоймлон оруулсан бөгөөд бүлэг тус бүрийн төгсгөлд мэдлэг сорих асуулт, сорилын дасгалтай ажээ. Тус бүтээл нь урлагийн түүхийг сонирхогч уншигч болон оюутан суралцагсад нэн чухал гарын авлага болно.


85(1)

М 692

/НХУУТ-5/

ЭШФ Б-29757-29758

Эрдэнэчимэг Л. **Чингисийн эр хоёр загал ардын дуу, зан үйлтэй холбогдох нь=Chinggis Khan's two stallions in depth to Mongolian folk song and customs:** Боть 1 / Ред. Л.Оюунчимэг; Хөрв. Цэлгэр.- УБ.: Удам соёл, 2019.- 193х.- ISBN: 999783654-5.- ISBN 978-9997-836540.



Судлаач энэхүү нэг сэдэвт бүтээлдээ ардын дуу хөгжим, ёс заншил, зан үйлийн талаас нь тусгайлан судалж, угсаатны хөгжим судлалын аргаар задлан шинжилсэн байна. Тус бүтээлд монголчуудын эртний шүтлэг бишрэл, байгаль, од эрхэс, тэнгэр газар, эртний ан ав хийх зан үйл, хоморгон авын тухай, анчин гөрөөчин авын хүн, отын хүн, туялзуурын хүн, сувийн хүн, хуурч хүн, боол Бичин гэх зэрэг эзэн хааны дэргэд байсан туслагч нарын тухай болон мал сэтэрлэх, амьтан шүтэх гэх мэт өдий төдий зан үйлтэй холбогдох мэдээ баримт, дуу хөгжмийн ая хэмнэлийн талаар тусгажээ.

85.3(1)+87.774

Э 739

/НХУУТ-7/

ЭШФ Т-23332-23334

Эрдэнэчимэг Л. **Монголчуудын модны шүтлэг ардын дуунд=Mongolian folk song reverence for tree:** Боть 2 / Ред. Л.Оюунчимэг.- УБ.: Удам соёл, 2019.- 297х. - ISBN: 978-99978-3-654-0.- ISBN 978-99978-7-010-0.



Монголчуудын эрт дээр үеэс шүтэж ирсэн модны шүтлэгийн тухай зан үйл нь ардын дуунд хэрхэн тусаж буусныг нарийн судлан шинжилсэн энэхүү нэг сэдэвт бүтээлд монгол үндэстэн ястнуудын дунд дуулагдаж ирсэн олон янзын модны тухай дуунуудын үүсэл домог, утгыг тайлбарлажээ. Судлаач бүтээлийнхээ ерөнхий бүтцийг монголчуудын ёс заншил дахь бага найрт 64 бөх барилдуулж, 64 эхтэй дуу дуулдаг байсан уламжлалаар 64 домог, $9 \times 9 = 81$ -ийн бэлгэдэл болгон 81-н эхтэй дууг сонгон авсан нь биет бус өвийн соёл уламжлалыг танин мэдүүлэх, цааш өвлүүлэн хөгжүүлэх үйлсэд чухал ач холбогдолтой гэж үзжээ.

85.3(1)+87.774

Э 739

/НХУУТ-7/

ЭШФ Т-23335-23337

Эрдэнэчимэг Л. **Онгодын шүтлэг модон цуурт=Wooden pipe reverence for totem**: Боть 3 / Ред. Л.Оюунчимэг.- УБ.: Удам соёл, 2019.- 224х.- ISBN: 978-99929-2-708-3.



Тус бүтээлд монгол түмний соёлын биет бус өвийн нэг болох "Алтайн модон цуур"-ын тухай эх хэрэглэгдэхүүнд тулгуурлан "Онгодын шүтлэг модон цуурт" гэсэн нүүдэлч монголчуудын онго, сахиус, сүр сүлд, сүнс сүлдэр, 33 овоон шүлэг, цуурын аялгууны 21 шинж байдал өвөрмөц дуурьслыг судлан шинжилжээ. Түүнчлэн модон цуурын уламжлалт зан үйлийг хойч үеийнхэнд өвлүүлэн уламжлуулах үүднээс анх удаа давхар ноотоор буулган бичсэн CD бичлэгийн хамт энэхүү номыг уншигч олноо толилуулж байна.

85.3(1)+87.774

Э 739

/НХУУТ-7/

ЭШФ Т-23338-23340

Эрдэнэчимэг Л. **Морин хуурын арга билгийн арван хоёр эгшиглэн=Twelve microtones of the horse headed fiddle** / Хөрв. Өлзийхишиг; Хян. Л.Оюунчимэг.- УБ.: Удам соёл, 2019.- 218х.- ISBN: 978-99978-701-1-7.



Энэхүү бүтээлд морин хуурын үүсэл хөгжлийг домог үлгэр түүхэн сурвалж бичгийн мэдээ баримтанд тулгуурлан ерөнхийд нь тусгаснаас гадна хүнээс хүнд уламжлагдаж ирсэн бодит өвийг хөгжмийн шинжлэлийн үүднээс авч үзсэн байна. Тус нэг сэдэвт бүтээл нь монгол хөгжмийн зэмсгийн судлалаар ялангуяа авиа эгшгийн сонсгол зүйн үүднээс судлагдаж буй анхны бүтээл юм.

85.3(1)+87.775

Э 739

/НХУУТ-7/

ЭШФ Т-23341-23343

ШАШИНСУДЛАЛ

Карритэрс Майкл. **Будда**: Тун товчхон танилцуулга / Орч. Т.Ариунсанаа.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 107х.- ISBN: 978-9919-500-30-6.



Тус бүтээлд Буддагийн бага нас, гэгээрлийн замд орсон үе, гэгээрсэн Будда ба бурхан багшийн зам мөрийн талаар өгүүлсний дээр бурханы сургаал номлолын үүсэл, ач холбогдол, бурхны сургаал номлол хэрхэн дэлхийд түгэн тархаж, өнөөг хүртэл олон зууны турш хүн төрөлхтний оюун санаанд оршсоор буй талаар тайлбарлахыг зорьсон байна.

86.35

К 268

/НХУУТ-4, ГНОФ-3/ ЭШФ Б-29700-29702

Хутагт Алтангэрэлт буюу судрын аймгийн дээд эрхэт хаан хэмээх их хөлгөн судар оршвой / Монгол хэлэнд хөрв. Б.Батбаяр; Хян. Б.Идэрбаяр; Техник. ред. Б.Нэргүй; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: НЕПКО, 2019.- 416х.- ISBN: 978-9919-500-28-3.

Санскрит хэлээр “Арьяа Суварна бравха сотта ма сутрэндра раза нама маха яана сутра”, төвд хэлнээ “Пагва Сэр од дамба, до дэй ванбу жалбу, шэйжава, тэгва чин буу до” хэмээн нэрлэгддэг “Хутагт Алтангэрэлт” судар нь нэгэн хутагт дээд тэнгэр, дагинасын зарлигийг зүүдэндээ сонсож буй хэлбэрээр бичигджээ. Сударт гэгээрэл нирваанд хүрэх арга замыг үзүүлсэн төдийгүй энэ насны элдэв аюул, цаг бусын үхэл зэргээс аврах ялангуяа эдийг хэрхэн бүтээх тухай дэлгэрэнгүй номложээ. Тиймээс энэ судрыг монголчууд “Эдийн тэнгэр Алтангэрэлт судар” хэмээн нэрлэдэг аж.



86.35

X 746

/НХУУТ-3/

ЭШФ Т-23460-23461

Ричэс Жон. **Библи:** Тун товчхон танилцуулга / Орч.Т.Ариунсанаа; Техник. ред. Б.Болдбаатар, В.Уянга; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 159х.- ISBN: 978-9919-500-29-0.



Энэхүү номонд Библийн тухай өөр өөр ард түмний тэмдэглэн үлдээсэн судруудын шинжилгээ судалгааны талаар тусгасны дээр Библи яагаад олон янзаар ойлгогддог, Библи ямар шүүмжлэл дагуулж байсан гэх зэрэг асуудлуудыг ч хөндсөн байна. Улмаар Библи өрнөдийн соёлд хэрхэн асар их нөлөө үзүүлснийг болон үүнийг поп урлагт болон улс төрд хэрхэн ашиглаж буй талаар тайлбарлажээ.

86.37

P 56

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б-29697-29699

ГҮН УХААН

Лувсанцэрэн Г. **Бүтээл туурвилын эмхэтгэл** / Эрх.хэвл. Ж.Лхагвадэмчиг; Эх бэлт. С.Янжинсүрэн.- УБ., 2019.- (МУИС-ийн профессорын эрдмийн өв).- ISBN: 978-9919504038.



МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлж буй “МУИС-ийн профессорын эрдмийн өв” цувралын энэ удаагийн дугаарт Монгол улсын ШУ-ны гавьяат зүтгэлтэн, буддын судлалын нэрт эрдэмтэн, академич Гэлэгжамцын Лувсанцэрэнгийн бүтээлээс толилуулж байна. 1-р ботид "Нагаржунагийн философийн үзэл" 1981 он, "Төв үзлийн философийн онолын үндэс" 2001 онуудад хэвлэгдсэн орчин үеийн монголд төв үзлийн философийн судалгааны дэг сургуулийн арга зүйн үндсийг тавьсан нэг сэдэвт 2 бүтээл, 2-р ботид "Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас" 2008 он, "Төв үзэл төвшин бодлого" 1994 онуудад хэвлэгдсэн 2 бүтээлээс гадна буддын философи судлалын арга зүй, үзэл баримтлалын талаарх судалгааны 3 өгүүлэл оржээ.



87.3

Л 82

Б.1: Нагаржунагийн философийн үзэл, төв үзлийн философийн онолын үндэс.- 290х.

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Т-23286-23290

Б.2: Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас төв үзэл төвшин бодлого.- 351х.

/НХУУТ-5, ГНОФ-5/

ЭШФ Т-23291-23295

Прист Грээм. **Логик:** Тун товчхон танилцуулга / Орч.Т.Ариунсанаа; Техник. ред. Б.Болдбаатар, В.Уянга; Хавтасны диз. Н.Бямбацогт; Эх бэлт. Д.Цэрэндулам.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.-160х.- ISBN: 978-99978-51-88-8.



Тус бүтээлд орчин үеийн логик гэж юу вэ?, логикийн талаар мэдэх яагаад ашигтай вэ?, Бурхан байдаг уу? гэх асуултаас авахуулаад магадлалын онолын дотоод зөрчлүүд, шийдвэр гаргалтын онолуудын тухай энгийн үг хэллэгээр тайлбарлажээ. Энэхүү номыг логикийн тухай хэзээ нэгэн цагт бодсон, бодох хүмүүст зориулав.

87.4

П 771

/НХУУТ-4, ГНОФ-3/

ЭШФ Б-29703-29705

Оюунчимэг Б. **Ёс зүй:** Ёс суртахууны тухай ном.- 4 дэх. хэвл.- УБ.: Бемби сан, 2019.- 388х.- ISBN: 978-99962-913-2-6.



Энэхүү бүтээлд ёс суртахууны үүрэг, үндсэн ойлголт, зарчим, хэм хэмжээ, ёс суртахууны алдаа зөрчил, мэргэжлийн ёс зүй, ёс суртахуун, шаардлагууд тэдгээрийг мэргэжилтнүүд хэрхэн мөрдөж байгаа, нийгмийн ёс суртахууны гажуудуулалт мөн ёс зүй, бизнесийн ёс зүй, хэрэглээний ёс зүйн тухай ойлголт, холбогдох нэр томъёо түүний хоорондын ялгааг тайлбарлажээ.

87.7

О 634

/НХУУТ-4/

ЭШФ Т-23491-23493

Фромм Э. **Хайрлах урлаг=The art of loving** / Орчуулгын зөвлөх С.Молор-Эрдэнэ; Орч. А.Баярцэцэг; Г.Баянжаргал, С.Батзориг ба бус.; Ред. Д.Мөнхцэцэг, Ч.Мөнхтуяа, Т.Очхүү, Н.Нямдорж.- УБ.: Мон судар, 2015.- 158х.- ISBN: 978-99973-1-189-4



Философич, психологич, социологич Э.Фроммын бичсэн энэхүү номонд хүн төрөлхтөний дээдийн дээд сэдэв болсон хайрыг хүндэтгэж, маш хариуцлагатай хандах, бас хайр гэдэг бол хэзээ ч хуучирч өөрчлөгдөхгүй, цаг үеэс хамааралгүй гэсэн ойлголт юм гэдгийг тод томруун тайлбарлажээ. Хайрыг хэрхэн ойлгож бас хэрхэн нэг нэгнээ хайрлаж буй тэр хайранд үндэстэн, ястан, улс орон, газар нутгийн ямар ч ялгаа байхгүй гэдгийг энэ номноос ойлгох боломжтой.

87.7

Ф 915

/НХУУТ-5, ГНОФ-4/

ЭШФ Б-29683-29685

СЭТГЭЛ СУДЛАЛ

Батболд Ш. **Сэтгэл судлал, сонгодгууд** / Ред. Б.Номин, Б.Золзаяа, Ж.Цэзэн; Хян. Б.Азжаргал; Эх бэлт. Т.Нарангуа.- УБ.: Мөнхийн үсэг, 2020.- 308х.- ISBN: 99978-936-6-2 978-99978-893666.



Сэтгэл судлалын үндэс, үүсэл хөгжил, судлах зүйл, тухайн шинжлэх ухааны сонгодог төлөөлөгчид болон зан үйлийн эволюци, сэтгэл судлалын орчин үеийн чиг хандлага, сэтгэл засал, сэтгэцийн өвчний эмчилгээ зэрэг өргөн агуулгыг хамарсан энэхүү бүтээлийг их, дээд сургуулийн сэтгэл судлалын үндсэн хичээлийн гарын авлага болгох зорилгоор бичжээ. Тус номын өмнөх хэвлэлтэд ороогүй суралцахуй, жендерийн сэтгэл судлал болон танин мэдэхүйн сэтгэц заслын талаархи үндсэн гол ойлголтуудыг энэ удаагийн хэвлэлд нэмж оруулсан байна.

88.3

Б 332

/НХУУТ-25, ГНОФ-70/

ЭШФ Т-23275-23279

НОМ ЗҮЙН ЛАВЛАГААНЫ ГАРЫН АВЛАГА

МУИС-ийн номын сангийн ном зүйн бүртгэл-I: Магистр, докторын судалгааны бүтээл: 1970-2018 он / Ерөн. ред. О.Нарантуяа; Ред. М. Кунай, Ж.Оюунчимэг; Эмхт. С.Найгалмаа, У.Гэрэлтуяа, Б.Алтанцэцэг ба бус.- УБ.: Бэмби сан, 2019.- 1039х.- ISBN: 978-9919-504-00-7.



Шинжлэх ухааны өргөн мэдлэгийн салбараар судалж, магистр, докторын зэрэг хамгаалсан эрдэмтэн судлаачдын бүтээлийг олон түмэн уншигчдад таниулах зорилгоор МУИС-ийн номын сангийн ном зүйн бүртгэлийн II дугаар цувралыг эмхэтгэн гаргаж байна. Энэхүү бүтээлд тус номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа монголд болон гадаадад хамгаалсан 6447 магистр, 661 докторын судалгааны бүтээлийн ном зүйн мэдээлэл багтсан бөгөөд төгсгөлд нь хэрэглэгчдэд хайлт хийхэд туслах хүний нэрийн хэлхээс, газар зүйн нэрийн хэлхээс, товчилсон үгийн тайлбарыг хийж хавсаргав. Тус бүтээлийг МУИС-ийн номын сангийн цахим сангаас унших боломжтой.

91

М 692 /ОУХНУС-5492-5496, ХЗС-5, ЛавФ-1, НХУУТ-6, БУУТ-5/ ЭШФ Т-23424-23426